



FEDERATION AGENCY OF GOVERNMENT
NATIONAL DEVELOPMENT AGENCY



2021 оны 6 дугаар сар

INVEST IN MONGOLIA

ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРААС ЭРХЛЭН ГАРГАВ
ДУГААР 05

АГУУЛГА

БНСУ-ЫН ШУУД ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ-БНСУ-ЫН
ХАРИЛЦАА

“INVEST IN MONGOLIA-SEOUL
2021” МОНГОЛ, БНСУ-ЫН БИЗНЕС
ФОРУМ

ТӨСЛҮҮДИЙН ТОВЧ
ТАНИЛЦУУЛГА

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ГОМДЛЫГ
ШИЙДВЭРЛЭХ МЕХАНИЗМ (ХОГШМ)-ЫГ
НЭВТРҮҮЛЭХЭД БНСУ-ЫН ЖИШГИЙГ
АШИГЛАСАН НЬ

МОНГОЛ, БНСУ-ЫН НӨХӨРЛӨЛИЙН
БЭЛГЭ ТЭМДЭГ “НОГООН ХЭРЭМ” ТӨСӨЛ

МОНГОЛ, БНСУ БИЗНЕС ФОРУМД
ЗОРИУЛСАН ТУСГАЙ ДУГААР

www.investmongolia.gov.mn

ЭРХЭМ УНШИГЧ ТАНД ЭНЭ ӨДРИЙН МЭНД ХҮРГЭЭ

Монгол Улсад бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагч Та бүхний энэ өдрийн мэндийг хүргэе! Мөн Танд зориулж эрхлэн "Invest in Mongolia" эмхтгэлийн 6 дугаар сарын дугаарыг хүргэж байгаадаа таатай байна.

Өнгөрсөн онд хоёр улсын дипломат харилцаа тогтоосны 30 жилийн ойн хүрээнд 2020 оныг "Монгол, Солонгосын найрамдлын жил" болгон зарлаж, олон арга хэмжээг зохион байгуулсан. Манай хоёр орон 1990 онд түүхэн дипломат харилцаа тогтоосноос хойш улс төр, худалдаа, эрчим хүч, хүрээлэн буй орчин, эрүүл мэнд, нийгмийн халамж зэрэг бүхий л салбарт хамтын ажиллагаагаа бэхжүүлэн, Иж бүрэн түншлэлийн харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлсээр ирлээ.

Бид Монгол улсын Ерөнхий сайдын удирдлага дор бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах цогц шинэчлэлийг эхлүүлээд байгаа билээ. Хөрөнгө оруулалтын цогц шинэчлэлийн хүрээнд хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин, хөрөнгө оруулалтыг дэмжих, хамгаалах, цар тахлын үеэр хөрөнгө оруулагчдад зориулсан цахимжилт, төрийн болон бусад байгууллагуудтай хамтарсан хөрөнгө оруулагчдад зориулсан үйлчилгээний хялбаршуулалт зэрэг ажлуудыг багтаасан болно.

Хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, хөрөнгө оруулалт татах, дэмжих чиглэлээр бодлогын зөвлөмж гаргах, хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилго бүхий Хөрөнгө оруулалтыг дэмжих зөвлөл болон Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг боловсруулахдаа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх хуулийн этгээдийн төлөөллөөр тухайн асуудлыг хэлэлцүүлж, санал авч, зөвшилцөл хийх, бизнесийн орчинд тулгарч буй асуудлыг хамтран шийдвэрлэх зорилго бүхий Бизнесийн зөвлөлийг байгуулах гэж байна. Эдгээр зөвлөл нь хариуцсан асуудлын хүрээнд зөвлөмж гаргаж, Ерөнхий сайд болон Засгийн газарт хүргэх чиг үүрэгтэй.

Мөн Үндэсний хөгжлийн газар нь 6 дугаар сард Солонгос улстай, 6 дугаар сард Бүгд Найрамдах Солонгос улстай хамтын ажиллагааг эдийн засаг, хөрөнгө оруулалтын салбарт өргөжүүлэх, хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдэд Монгол Улсын хөрөнгө оруулалт, бизнесийн орчны талаарх шинэ мэдээллийг хүргэх зорилготойгоор Хөрөнгө оруулалтын форумуудыг зохион байгуулж, байгааг уламжлахдаа таатай байна.

Энэхүү товхимолтой холбоотой санал хүсэлтийг манай газрын info@nda.gov.mn цахим хаягаар ирүүлнэ үү.



Үндэсний хөгжлийн газрын дэд дарга
Б. БУЛГАНЧИМЭГ

Та бүхнийг хүндэтгэсэн
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР

СОЛОНГОСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД ТӨСЛӨӨ ТАНИЛЦУУЛНА

"INVEST IN MONGOLIA – SEOUL 2021" МОНГОЛ - СОЛОНГОСЫН БИЗНЕС
ФОРУМЫН ТАНИЛЦУУЛГА

Монгол, Солонгосын худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдөр Үндэсний хөгжлийн газар, Солонгосын Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжиг агентлаг /KOTRA/, Монгол Улсаас Солонгос улсад суугаа ЭСЯ, Олон Улсын Санхүүгийн Корпораци (IFC), Ирбис Венчурс компанитай хамтран "Invest in Mongolia - Seoul 2021" Монгол, Солонгосын бизнес форумыг цахимаар зохион байгуулах гэж байна. Дэмжигч байгууллагаар Монгол Улсын Гадаад харилцааны яамтай хамтран ажиллаж байна.

Форумын хүрээнд Солонгосын хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдэд Монгол Улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалт, бизнесийн орчныг сайжруулах шинэчлэлийн төлөвлөгөөг танилцуулахаас гадна Монгол Улсад хөрөнгө оруулж, бизнес эрхэлж буй Солонгосын хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдийн төлөөллүүд туршлагаасаа хуваалцана.

Үндэсний төсөл хэрэгжүүлэгч компаниудыг дэмжих зорилгоор Үндэсний хөгжлийн газар, Сингапур улсад төвтэй Ирбис Венчурс болон Жи-Эм-Жи Консалтинг компанитай хамтран "Төсөл чадавхижуулах хөтөлбөр"-ийг зохион байгуулж, шалгарсан төслүүдийг 1 сарын турш чадавхижуулсан бөгөөд эдгээр төслүүдийг форумын үеэр БНСУ-ын улсын хөрөнгө оруулагчдад танилцуулна.

Өөрөөр хэлбэл, орчин үеийн хамгийн их анхаарал татаж буй бизнесийн салбарууд болох мэдээллийн технологи, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, сэргээгдэх эрчим хүч, технологийн салбарын төслүүдийг танилцуулна.

Арга хэмжээний болон төслүүдийн дэлгэрэнгүй мэдээллийг

www.korea.investmongolia.gov.mn

авна үү.



Зохион байгуулагч байгууллагууд:



Дэмжигч байгууллагууд:



МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ТОВЧ



Хүн ам

3.2 САЯ



ЖИЛ ТУТАМ ДУНДЖААР

70,000

ХҮҮХЭД ШИНЭЭР ТӨРЖ БАЙНА.

ДНБ

13.32

ТЭРБУМ АМ.ДОЛЛАР

5.1 %

ӨСӨЛТ (2021 ОНЫ
УРЬДЧИЛСАН БАЙДЛААР)

Газар нутаг

1.5 САЯ КМ²

ГАЗАР НУТГИЙН
ХЭМЖЭЭГЭЭР

17



ДАЛАЙД
ГАРЦГҮЙ



Нийт ГШХО

29.6

(1990-2020)

ТЭРБУМ АМ.ДОЛЛАР

(123 ОРНООС ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ ХИЙГДСЭН)

ТОП ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ

5 УЛСУУД:



КАНАДА ЧИНА ГЕРМАНИА ХУНГАРИ СИНГАПУР

НИЙТ
ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН

70%

ОЛБОРЛОХ САЛБАРТ ХИЙГДСЭН.

Экспорт

7.6

ТЭРБУМ АМ.ДОЛЛАР

(142 УЛСТАЙ) (2020)

72.5%



ТОП ЭКСПОРТ:

2.7

ХҮРЭН НҮҮРС
ТЭРБУМ АМ.ДОЛЛАР

2.1

ЗЭСИЙН ХҮДЭР
ТЭРБУМ АМ.ДОЛЛАР

ТОП ЭКСПОРТЫН БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД:



28%
ХҮРЭН НҮҮРС



23.6%
БОЛОВСРУУЛГАГҮЙ ЗЭСЛЭЛ
ХАЛАС БОЛОВСРУУЛСАН
ЗЭЛБЭРЭЭР АЛТ



23.5%
ЗЭСИЙН ХҮДЭР



8.4%
ТӨМРИЙН ХҮДЭР
БА БАЯЖМАЛ



НООЛУУР, НООС
(ИЛЭВЭР БОЛОВСРУУЛГАГҮЙ)



ЭРДЭНИЙН
ЧУЛУУ



АЛТ

НӨӨЦ БОЛОМЖУУД:



ЭРЧИМ ХҮЧ ИНАВ САЛХИЙН
ЭРЧИМ ХҮЧНИЙ БОЛОМЖ нь
СУУРИЛГА ДЭЛН ХҮЧНИЙ
ЧАДАЛТАЙ ӨНДӨУ 2000 ГИГАВАТТ
[ГВТ] -ТАЙ ТЭНЭ (ХӨНӨ) ӨНДӨУ
5,457 ТЕРАВАТТ ЦАЦАГ ЦЭВЭР
ЦААХИ ААН ҮЙЦЭРЭННЭХ
БОЛОВСРУУЛСАН ТУСГАН ТУСГАН
ГАРГАХ



ГАЗРЫН
ХӨВӨР
ЭЛЕМЕНТ
ЭЛЭМЭНТ
ЭЛЭМЭНТ
ЭЛЭМЭНТ
ЭЛЭМЭНТ



НООЛУУР,
НООС,
НООЛУУРАН
БҮТЭЭГДЭХҮҮН
БОЛОВСРУУЛСАН



ОРГАНИК
АРЬС
АРЧИЛГАА



ОРГАНИК
ЗӨГИЙН
БАЛ,
ЧАЦАРГАНА



БОЛОВСРУУЛСАН
АРЬС, ШИР,
АРЬСАН ЭДЛЭЛ



МАХ, ҮХЭР,
ХОНИНЫ
МАХ, ХАЛАЛ
МАХ



СҮҮН
БҮТЭЭГДЭХҮҮН

МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ТОВЧ

Импорт

5.3

ТЭРБУМ АМ.ДОЛЛАР
(72 УЛСТАЙ)



ТОП ИМПОРТЛОГЧ УЛСУУД:



ТОП ИМПОРТ:



БОЛОВЧУУЛАН
НӨГДӨ

1.0
ТЭРБУМ АМ.ДОЛЛАР



ГАЗИНИУЦ, БОЛОН
ДЭ АНГУУД

815
САЯ АМ.ДОЛЛАР



БЭЛЭН БОЛОВЧУУЛСАН
ХҮНС



ХАМИН
БҮТЭЭГДЭХҮҮНҮД



ХҮНСНИЙ НОГОО,
ЖИНС ЖИНСЭНЭ



ГАН

Ковид19 вакцинжуулалт

2021 ОНЫ 5-Р САРЫН 1
БАЙДЛААР

МОНГОЛ УЛС ӨДӨРТ ДУНДЖААР

70,000



ХАЛДВАЛ ХЭЛДЭГЭЭН ЦАХИЛГАЖУУЛАЛТ
ХЯМЖААГАА ӨНДӨР ЖАЛСНАА,
ТОЙТОН.

Соёл

МОНГОЛЫН СОЁЛ
БОЛ БӨӨ МӨРГӨЛ,
БУДДЫН ШАШНЫ
ИТГЭЛ ҮНЭМШИЛ
ШИНГЭСЭН
НҮҮДЭЛЧДИЙН
ҮНЭТ ЗҮЙЛ, ӨВ
УЛАМЖЛАЛААР
БАЯЛАГ БИЛЭЭ.

Хөдөлмөр эрхлэлт



68.3% **53.4%**



ХҮН АМЫН ТАЛ ХУВИЙГ
27-00С ДООШ НАСНЫХАН

98%

БИЧИГ ҮСЭГ ТАЙЛАГДСАН

68.6%

ДЭЭД БОЛОВСРОЛТОЙ

ЖИЛД ДУНДЖААР
8.06%
ӨСЧ БАЙНА.

Цаг агаар

ДАЛАЙ ТЭНГИСЭЭС
АЛСЛАГДСАН, ӨНДӨРЛӨГ
ГАЗАРТ БАЙРЛАДАГ ТУЛ ЭХ
ГАЗРЫН ЭРС ТЭС УУР
АМЬСГАЛТАЙ -30 ХЭМ
ХҮРДЭГ МАШ ХҮЙТЭН ӨВӨЛ,
БОГИНО, ГЭХДЭЭ ДУЛААН ЗУН
БОЛДОГ, ЯЛАНГУЯА ГОВЬ
ЦӨЛД.

Монголд амьдрахуй



УЛААНБААТАР ХОТ
1.5 САЯ

100

ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА
ЭЛЧИН САЙДЫН ЯАМ, ҮНДЭСТЭН
ДАМНАСАН КОМПАНИУД БАЙДАГ



21 АЙМАГ
333 СУМ



ГЭМТ ХЭРЭГ
ХАМГИЙН БАГА ГАРДАГ
УЛСУУДЫН НЭГ ЮМ.

УЛААНБААТАР ХОТ НЬ **БЭЭЖИН, СӨҮЛ, ТОКИО, ХОНКОНГ** ЗЭРЭГ ДЭЛХИЙН
ТОМРОХОН ХОТУУДААС **1.5-4 ЦАГИЙН** ВАЙТАЙ.

MON ENG

АЛБАН ЁСНЫ ХЭЛ НЬ
МОНГОЛ ХЭЛ БОЛОВЧ,
АНГЛИ ХЭЛИЙГ ҮГ
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ НЭГ
ХЭЛБЭР БОЛГОЖ
ТОДОРХОЙ ХЭМЖЭЭГЭЭР
АШИГЛАЖ БОЛНО.

Хоол хүнс

МОНГОЛ ХООЛ НЬ ГОЛДУУ **СҮҮН**
БҮТЭЭГДЭХҮҮН, МАХ, АМЬТНЫ
ГАРАЛТАЙ ӨӨХ ТОСНООС
БҮРДДЭГ МОНГОЛ ОРНЫ ЭХ
ГАЗРЫН ЭРС ТЭС УУР АМЬСГАЛ
НЬ УЛАМЖЛАЛТ ХООЛ
ХҮНСЭНД ШИНГЭСЭН БАЙДАГ.
ХҮНСНИЙ НОГОО, ХАЛУУН
НОГООНЫ ХЭРЭГЛЭЭ
ХЯЗГААРЛАГДМАЛ БОЛОВЧ ТОМ
ХОТУУДАД ХЭРЭГЛЭХ НЬ ЭЛБЭГ.



Засаглал

МОНГОЛ УЛСЫН УЛС ТӨР НЬ **ХАГАС**
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН, ОЛОН НАМЫН ТӨЛӨВЛИЙН
ДРДЧИЛСАН ЗАРЧМААР ЯВАГДДАГ ГҮЙЦЭТГЭХ ЭРХ
МЭДЛИЙГ ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ТЭРГҮҮН **ЕРӨНХИЙ САИД**
ЭРХЭЛДЭГ. ХУУЛЬ ТОГТООХ ЭРХ МЭДЛИЙГ
ПАРЛАМЕНТ ЗАСАГЛАЖ, ШҮҮХ ЗАСАГЛАЛ НЬ
ГҮЙЦЭТГЭХ БОЛОН ХУУЛЬ ТОГТООХ
БАЙГУУЛЛАГААС **ХАРААТ БУС** БАЙДАГ.



МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ТОВЧ

Олон улсын байгууллагуудын үзүүлэлт (2020)



МОНГОЛД БИЗНЕС ЭРХЛЭХҮИ -
АЗИ НОМХОН ДАЛАЙН ОРНУУДЫН ДУНД 10ЭРТ



**БАРИЛГЫН
ЗӨВШӨӨРӨЛ
АВАХ 6ЭТ**



**ХӨРӨНГӨ
БҮРТГҮҮЛЭХ
6ЭТ**



**ЗЭЭЛ АВАХ
4ЭТ**



**ХӨРӨНГӨ
ОРУУЛАГЧИЙН
ХАМГААЛАЛ 6ЭТ**



**ТАТВАР ТӨЛӨЛТ
7ЭТ**

**МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛЖИХ
ЗЭРЭГЛЭЛ (MOODY'S)**

B3

ТОГТВОРТОЙ

Олон улсын зах зээлд нэвтрэх боломжууд, давуу талууд

**ЭДИЙН ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ
МОНГОЛ УЛС, ЯПОН УЛС ХООРОНДЫН
ХЭЛЭЛЦЭЭР (JMEPA)**

Монголын талдас **5,700**
Японы талдас **9,300**

(Торлийн баримт бичгэд хүүхний ай хөрөнгийн хамтарсан татварын тасгийг татваргаас шууд бонгог үр шалтгайгаар нөлөөлөх)

**ЕВРОПЫН ХОЛБООНЫ ХӨНГӨЛӨЛТИЙН
ЕРӨНХИЙ СИСТЕМ GSP+**

2019 Баруун бүтээгдэхүүнийг 2X-н улсуудад гаалийн татварын хөнгөлөлт

**АНУ-ЫН ХӨНГӨЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ
СИСТЕМ GSP+**

АНУ-ын зах зээлд 2019 гаруй бүтээгдэхүүнд гаалийн татваргүй нэвтрэх нөхцөл

**АЗИ НОМХОН ДАЛАЙН ХУДАЛДААНЫ
ХЭЛЭЛЦЭЭР (ЭНЭТХЭГ, ӨМНӨД
СОЛОНГОС, ШРИ ЛАНКА, ЛАОС,
БАНГЛАДЕШ, БНХАУ)**

Ишүүн улсын зах зээлд **10,057** торлийн баримт бичгэд хүүхний тасгийг бууруулах

Монгол Улсын хөрөнгө оруулалтын боломжууд

ТЭРГҮҮЛЭХ	САЛБАРУУД ОЛОН УЛС ДАХ БАЙР СУУРЬ	НӨӨЦ	Батлагдсан нөөц	Дэлхийд эзлэх байр суурь
Уул уурхай 	Монгол Улс 11.7% орчим идэрдэг буй орд, 80 гаруй торлийн ашигт малтмалыг 110000 гаруй агаар бүхий долхийн нөөцөөрөө долхийн /-о байршилд жигтэй байна. Салбарын боломжууд: - Хайгуулын тусгай зөвшөөрөл - Шинэ боловч суваг, хөдөлгөөн оруулалт - Хайх - зорилгод, зэрэг нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлдэг - Тээврийн хөдөлгөөн, тийг хайх, олборлох	Ашигт малтмал		
		Зэс	5.7 сая тонн	12р
		Нүүрс	34.2 тэрбум тонн	23р
		Төмрийн хүдэр	1.2 тэрбум тонн	19р
		Алт	2,500 тонн	
		Дайс	1.7 сая тонн	
		Жонц	48.3 сая тонн	4р
Уран	197.0 млн тонн			
Газрын тос	332.6 сая тонн	76р		

Уул уурхай, хүнд үйлдвэрлэлээрээ дэлхийд:



хайгууль, конвейер үйлдвэрлэлээр **8р**



каксжик, нүүрсний олборлолтоор **7р**



молибден ба зог афрам (Mo Content) -аар **10-рт**



зэсийн үйлдвэрлэлээр **16-рт**

МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ТОВЧ

Монгол Улсын хөрөнгө оруулалтын боломжууд

ТЭРГҮҮЛЭХ

Хөдөө аж ахуй



- Ногоо уурын нөөц дөрөвөө **201**
 - Ногоо нь өндөр орноос Азидаа **4-р**
 - Адууны малын үйлдвэрлэлээр **2-рт**
 - Хонь, ямааны мах үйлдвэрлэлээр Азидаа **2-рт**
- Basco, Vuhrotu, Moxintest, McQuay-н зэрэг төрөл зүйл бүрдүүд, Монгол ноогоор, ногоон харгалдаг.

Салбарын боломжууд:

- Мех, суурийн чөлөөтийн эрчимжсэн өрх ахуй хөгжүүлэх
- Органик бүтээгдэхүүн, нэцгэрлэн бүтээгчийн бэлтгэл
- Мех аж ахуйн төх
- Дотоодын харгалзаны хүнсний ногоо тариалалт

НӨӨЦ



67 сая

толгой малтай



1.3 сая га

тариалан тарих боломжит талбайтай.



31 хувь

ДНБ-ий 31 хувийг ХАА, хөнгөн үйлдвэрийн салбар бүрдүүлдэг.

Сэргээгдэх эрчим хүч



Азийн эрчим хүчээр хангах боломжтой нэрв, салжаны давхардлыг үй нөөцтэй.

Монгол Улс нь дэлхийн сэргээгдэх эрчим хүчний нөөцийн гуравны нэгийг хүртэх боломжтой улсын хувьд, Азийн эрчим хүчний сулор бүтээгч болох боломжтой.

МОНГОЛ ИЛЭД 2,900-г (саяватт (1.3) нарв, салжаны эрчим хүчний эрчимжүүлэлт суурийн үйлдвэрлэх боломжтой. Энэ нь жилд 5,457-г (саяватт (1.8) цаг байдалд, эелтэй цагаар эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадал гэсэн үг юм. Энэхүү нөөцөөс эрчим хүчний дотоодын харгалзлыг (2018 оны байдлаар 1.2 (1.8) эрчим) бүрэн хангаад, зогсохгүй эрчим хүч дамжуулах дад бүтцийг өндөр өйд шилсэн тохиолдолд Зүүн хойд Азийн бүс нутгийн эрчим хүчний аргаллыг хангах боломжтой юм. Дэлхийн газар Төрөөс эрчим хүчний талаар 2015-2030 онд баримтлах бооллын хүрээнд эрчим хүчний системийн нийт суурийн агаарын хувианд, сэрэлдэх эрчим хүчний агаар хувь хэмжээг **2023 онд 23% д, 2030 онд 30% д** тус тус харгалзам дүрлэх зорилт тавьсан байна.



Цаашдын боломж: Азийн сулор бүтээгч

Мэдээллийн технологийн салбар Fintech & banking



Монгол Улс, схионлогийн компаниудад ашиг агааргүй өсөлт болж буй боломжийн талын нэг юм. Энэ боломжтой өйд, агаар агаар мэдээллийн технологийн ажиллагсдын агаар агаар хөдөлмөрийн нөөц байдаг. Бөөдөд агаар хөгжлийн бусад хөгжлийн салбартай өрсөлдөх чадвартай байдаг.

Интернет харгалзлыг **23%**

Хувьд, улс харгалзлыг **9.4 сая (54%)** нь (20-56) харгалзлыг

Хувьд, улс харгалзлыг **9.4 сая (54%)** нь (20-56) харгалзлыг

Хувьд, улс харгалзлыг **9.4 сая (54%)** нь (20-56) харгалзлыг

Хувьд, улс харгалзлыг **9.4 сая (54%)** нь (20-56) харгалзлыг

Хувьд, улс харгалзлыг **9.4 сая (54%)** нь (20-56) харгалзлыг

Хувьд, улс харгалзлыг **9.4 сая (54%)** нь (20-56) харгалзлыг

Хувьд, улс харгалзлыг **9.4 сая (54%)** нь (20-56) харгалзлыг

Хувьд, улс харгалзлыг **9.4 сая (54%)** нь (20-56) харгалзлыг

Хувьд, улс харгалзлыг **9.4 сая (54%)** нь (20-56) харгалзлыг

Хувьд, улс харгалзлыг **9.4 сая (54%)** нь (20-56) харгалзлыг

Хувьд, улс харгалзлыг **9.4 сая (54%)** нь (20-56) харгалзлыг

Хувьд, улс харгалзлыг **9.4 сая (54%)** нь (20-56) харгалзлыг

Хувьд, улс харгалзлыг **9.4 сая (54%)** нь (20-56) харгалзлыг

Хувьд, улс харгалзлыг **9.4 сая (54%)** нь (20-56) харгалзлыг

Хувьд, улс харгалзлыг **9.4 сая (54%)** нь (20-56) харгалзлыг

Хувьд, улс харгалзлыг **9.4 сая (54%)** нь (20-56) харгалзлыг

Хувьд, улс харгалзлыг **9.4 сая (54%)** нь (20-56) харгалзлыг



Тээвэр логистик



Монгол бол Ази, Европийн холбоосон тээвэр, логистикийн **45-н** (саяватт) (саяватт) (саяватт) юм.

20 хоног агаар зорчих далайн замтай харьцуулахад, хуурай талын замгаар **11** хоног агаар зорчдог.

2014 онд ОХУ, БНХАУ-ын хооронд, тэмдэгт замгаар тээвэрлэсэн нийт бараа аргалтийн **50%** нь

Забайдалдсан Манжуур боомтод, **60%** нь Монголоор, **40%** нь Казахстангаар дамжин агаар зорчдог.

Цаашдын боломжууд:

Зам ба бүс

Орос, Хятадыг холбоосон хийн хоолой

МОНГОЛ УЛСЫН ТУХАЙ ТОВЧ

Хөрөнгө оруулагчийн хувьд Монгол Улс Танд:

ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛЖ

- Гадаадын хөрөнгө оруулагчтай эрх тэгш ханддаг бодлого
- Таны бизнес цэцэглэн хөгжихөд зориулсан тогтворжуулалтын бэлтгэл
- Эдийн засгийн чөлөөт бүсэд Татварын хөнгөлөлт чөлөөлөлт эхний 5 жил
- 60 + 40 хүртэлх жилийн хугацаатай газар ашиглах эрх
- Инновацилаг, бүтээлч гаргааны бизнесүүдэд илүү боломжийг олгож ямар нэгэн хязгаарлалтгүйгээр шинэ бизнесээ туршиж sandbox аргыг санал болгож байна.



ЦАХИМЖСАН ҮЙЛЧИЛГЭЭНҮҮД

- Галалын хөрөнгө оруулагчтай эрх тэгш ханддаг бодлого
- Таны бизнес цэцэглэн хөгжихөд зориулсан тогтворжуулалтын бэлтгэл
- Эдийн засгийн чөлөөт бүсэд Татварын хөнгөлөлт чөлөөлөлт эхний 5 жил
- 60 + 40 хүртэлх жилийн хугацаатай газар ашиглах эрх
- Инновацилаг, бүтээлч гаргааны бизнесүүдэд илүү боломжийг олгож ямар нэгэн хязгаарлалтгүйгээр шинэ бизнесээ туршиж sandbox аргыг санал болгож байна.



ТАНД ЗОРИУЛСАН ДЭМЖЛЭГ, СУРТАЛЧИЛГАА

- Хөрөнгө оруулагчдад зориулсан нэгдсэн мэдээллийн хуудас www.investmongolia.gov.mn-д зочлох
- Хөрөнгө оруулагчдад зориулан англи, монгол хэл дээр сар тутам эрхлэн гаргадаг "Invest in Mongolia" цахим сэтгүүл
- Хөрөнгө оруулалт хийх бизнесийн төслүүдийг Pitchbook 2021-нээс
- Үндэсний бизнесүүдийг оло-улсын зах зээлд сурталчлах, хөрөнгө оруулагчдад танилцуулахад дэмжлэг үзүүлэх зорилготой "Төсөл чадаажуулах хөтөлбөр"
- Удаачтай болж "Invest in Mongolia" Tokyo 2021, Соул 2021 арга хэмжээнүүдэд бүртгүүлэх
- Дараах манай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зочилж, шинэлэг мэдээлэл авч байгаарай-<https://www.facebook.com/inda.gov.mn> <https://twitter.com/inda.gov.mn>



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИЙН ХАМГААЛЛЫН МЕХАНИЗМ:



- Хөрөнгө оруулалттай холбоотой өргөдөл гомдлыг www.ird.gov.mn эсвэл Ерөнхий сайдын удирдсан Хөрөнгө оруулалтын зөвлөлөөр лавжуулан шийдвэрлэдэг
- Дүүх үйлчилгээ нь олон улсын гэрээ, конвенц, үндэсний хууль тогтоомжийн дагуу үүсэх мөргөөний шийдвэрлэх боломжтой
- Танд бизнес эрхлэх, хөрөнгө оруулалт хийхэд туслах чадварлаг, мэргэжлэн мэргэжилтнүүдтэй /home doctors/ ажлын алба нь Үндэсний хөгжлийн газарт ажилладаг
- Үндэсний хөгжлийн газрын ажилтнууд Монгол Улсад таны өмнөөс бусад талуудтай гэрээ байгуулж таны бизнес, хөрөнгө оруулалтын хамгаалалтыг баталгаажуулна
- Монголд бусад талуудтай хамтран ажиллахад таны Танд бизнес, хөрөнгө оруулалтыг хамгаалахад дэмжлэг үзүүлнэ.

МОНГОЛ УЛС, БНСУ-ЫН ХАРИЛЦАА

Монгол Улс, БНСУ 1990 оны 3 дугаар сарын 26-нд дипломат харилцаа тогтоосон. БНСУ Улаанбаатар хотноо 1990.06.18-нд, Монгол Улс Сөүл хотноо 1991.02.01-нд тус тус Элчин сайдын яамаа нээсэн. Монгол Улс, БНСУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 30 жилийг ой 2020 онд тохиосон бөгөөд энэ оныг “Монгол, БНСУ-ын найрамдлын жил” болгон зарлаж ёслол төгөлдөр тэмдэглэв.

БНСУ-ын Ерөнхийлөгч Ли Мен Баг-ийн Монгол Улсад 2011 онд хийсэн айлчлалын үеэр Монгол Улс-БНСУ-ын харилцааг “Иж бүрэн түншлэл”-ийн түвшинд хөгжүүлэхээр тунхагласан.

Монгол Улс, БНСУ-ын Засгийн газар хоорондын Хамтарсан хороо 2014 оноос хойш жил бүр хуралдаж хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны олон талт асуудлыг хэлэлцэж байна. Хоёр улсын хууль тогтоох байгууллагын харилцаа амжилттай хөгжиж

байгаа бөгөөд Улсын Их Хуралд Монгол Улс, БНСУ-ын парламентын бүлэг ажилладаг.

Түүнчлэн хоёр улсын батлан хамгаалах, зам тээвэр, хөдөө аж ахуй мөн боловсрол, болон эрүүл мэндийн яамдууд зөвлөлдөх уулзалт тогтмол хийдэг. Монгол Улс, БНСУ-ын худалдааны нийт бараа эргэлт 2020 оны 12 дугаар сарын байдлаар 257,18 сая ам.доллар, үүнээс экспорт 21,42 сая ам.доллар, импорт 235,76 сая ам.доллар болсон. 2019 онд худалдааны нийт бараа эргэлт 294,7 сая ам.доллар, үүнээс үүнээс манай экспорт 27,8 сая ам.доллар, импорт 266,9 сая ам.доллар байсан болно. БНСУ-тай хийж буй худалдаа манай улсын нийт импортын үнийн дүнгийн 4.4 хувь, экспортын 0.3 хувийг эзэлж байна.

БНСУ Монгол Улсын ардчилал, зах зээлийн тогтолцоонд шилжих үйл явцыг анхнаас нь дэмжиж, эдийн засгийн шинэчлэлийг

амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлсэн. БНСУ Монгол Улсад 1991 оноос буцалтгүй тусламж, 1993 оноос хөнгөлөлттэй зээл олгож байна. Хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд хоёр улс боловсрол, эрчим хүч, байгаль орчин, дэд бүтэц, аялал жуулчлал мөн мэдээллийн технологийн салбарт хамтран ажиллаж байна.

Хоёр улсын хамтын ажиллагааг эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалтын салбарт идэвхжүүлэх, өргөжүүлэх зорилгоор Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах боломжийг судлах хамтарсан судалгааг хийж байна. Монгол Улс 2021 оны 1 дүгээр сарын 1-нээс Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр –АПТА-д нэгдсэн нь хэлэлцээрийн тал БНСУ-тай худалдаа, эдийн засгийн харилцааг цаашид гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд түлхэц өгөх алхам болов.



2020 MONGOLIA - REPUBLIC OF KOREA FRIENDSHIP YEAR



МОНГОЛ УЛС, БНСУ-ЫН ХООРОНД ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТООСНЫ 30 ЖИЛИЙН ОЙ 2020 ОНД ТОХИОВ.

Монгол Улс, БНСУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 30 жилийн ой 2020 онд тохиож, хоёр улсын найрсаг харилцааг бэлгэдэн 2020 оныг “Монгол, БНСУ-ын найрамдлын жил”-ээр зарлан тэмдэглэсэн. Гадаад харилцааны яам, БНСУ-ын ЭСЯ-тай хамтран “Монгол Улс, БНСУ-ын түншлэлийн харилцаа - 30 жил” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал, гэрэл зургийн үзэсгэлэнг зохион байгуулсан ба үзэсгэлэнд тус яамны төв архиваас гадна БНСУ-ын Засгийн газрын архив, судлаачид болон ахмад дипломатуудаас цуглуулсан 50 орчим түүхэн гэрэл зургуудыг анх удаагаа үзмэр болгон гаргаснаараа онцлог болж өнгөрсөн юм.




ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Монгол Улсад 1990 оноос 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 123 орноос 29.6 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгдээд байна. Нийт 123 орны 15008 гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж бүртгэгдсэнийг улсаар нь авч үзвэл, нийт хөрөнгө оруулалтын 26.93 хувь буюу 7.9 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг Канад улс Монгол Улсад

оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээгээрээ тэргүүлж байна. БНХАУ 5.6 тэрбум ам.долларын 7543 аж ахуйн нэгж бүртгэгдсэн нь аж ахуйн нэгжийн тоогоороо 50.26 хувийг эзэлж, хөрөнгө оруулалтын хэмжээгээрээ нийт хөрөнгө оруулалтын 19 орчим хувийг эзэлж хоёрдугаарт жагсаж байна. Гуравдугаарт, нийт хөрөнгө оруулалтын 15 орчим хувь буюу 4.3 тэрбум

ам.долларын хөрөнгө оруулалтыг Нидерланд улс оруулж, нийт хөрөнгө оруулалтын 7 орчим хувь буюу 2.1 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг Люксембургээс оруулж дөрөвдүгээр байранд жагсаж байна. Сингапур улс нийт хөрөнгө оруулалтын 5.6 хувь буюу 1.6 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг хийж тавдугаар байранд жагсжээ.

ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ




Хөрөнгө оруулсан компанийн тоогоороо БНХАУ нийт компанийн 50 орчим хувь буюу 7543 компаниар тэргүүлж,

БНСУ 16.9 хувь буюу 2545 компани, ОХУ 6 орчим хувь буюу 904 компани, Япон 4.4 хувь буюу 670

компани, АНУ 2.2 хувь буюу 335 компанитайгаар тус тус байрыг эзэлжээ.

ГШХО ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН ААН / ОНООР /



БНСУ-ЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАЙ ААН / ОНООР /




Эх сурвалж : УБЕГ www.burtgel.mn

БНСУ-аас Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 575 сая ам доллар орчим байгаа нь Монгол улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын 1.94 хувийг

эзэлж байна. Үүнээс авч үзвэл Худалдаа, нийтийн хоолны салбарт 52.64 хувийг, Геологи, уул уурхайн эрэл хайгуул, олборлолт 12.98 хувь, Инженерийн барилга байгууламж, барилгын

материалын үйлдвэрлэлд 4.98 хувь, Мэдээлэл, холбооны технологи 2.94 хувь, Эрүүл мэнд, гоо сайхны үйлчилгээ 2.32 хувь байгаа болно.

БНСУ-ЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ /САЯ АМ.ДОЛЛАР/



БНХАУ-ЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ /САЛБАРААР/



- 52.64% Худалдаа, нийтийн хоол
- 26.46% Бусад
- 12.98% Геологи, уул уурхайн эрэл хайгуул, олборлолт
- 4.98% Барилга
- 2.94% Мэдээлэл, холбооны технологи

Эх сурвалж : Монгол Банк www.mongolbank.mn

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ:

МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛИЙН ТӨЛӨВИЙГ САЙЖРУУЛЛАА

Засгийн газрын гадаад, дотоод өр төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулан хөрөнгө оруулагчид, зээлдүүлэгчдийн өмнө хүлээсэн үүргээ хариуцлагатай биелүүлж байна.

Зээлжих зэрэглэл тогтоогч “Мүүдиз” агентлаг 2021 оны 3 дугаар сарын 16-ны өдөр Монгол Улсын зээлжих зэрэглэлийг В3- хэвээр хадгалж, төлөвийг “тогтвортой” болгож ахиуллаа. Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөллөөр буураад байсан

Монгол Улсын эдийн засаг тогтворжиж, уул уурхайн экспорт ялангуяа нүүрс, алт, зэсийн экспорт 2020 оны 2 дугаар хагаст сэргэж, гадаад валютын нөөц сайжирсан төдийгүй Засгийн газраас цар тахлын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн, өрийн дахин санхүүжилтийн арга хэмжээг амжилттай хийсэн зэрэг үйл явц нь зээлжих зэрэглэлийн төлөвийг “тогтвортой” болгоход гол нөлөө үзүүлсэн байна.



ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР:

НҮБ-ЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТАРСАН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛНЭ

Үндэсний хөгжлийн газрын дарга Х.Батжаргал болон НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (UNFAO)-ын Монгол улс дахь суурин төлөөлөгч Винод Ахужа нар 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх салбар болох Хүнс, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэхэд салбарын бодлогыг оновчтой тодорхойлж, хамтын ажиллагааг өргөжүүлэх, эрчимжүүлэх чиглэлээр хамтарсан төсөл хэрэгжүүлэх гэрээнд гарын үсэг зурлаа.

Төслийн зорилго нь хүнс, хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг дэмжих, тогтвортой хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдлын бодлогын хүрээг сайжруулах цаашлаад ядуурал, тэгш бус байдлыг бууруулж, ажлын байр бий болгоход оршино. Уг төсөл хэрэгжсэнээр эдийн засгийн өсөлтийг хангах, тогтвортой хөгжлийг дэмжих, малчид, тариаланчид болон хэрэглэгчдийг холбосон хөдөө аж ахуйн тогтолцоог сайжруулж, оролцогч бүх талуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх ач холбогдолтой.

Монгол Улсын хүн амынхаа хүнсний хэрэглээг дотоодын үйлдвэрлэлээр хангах түвшин сүүлийн жилүүдэд нэмэгдэж, зарим хүнсний бүтээгдэхүүний хэрэглээг дотоодын ургацаас хангаж байгаа төдийгүй, органик хүнсний бүртгэл мэдээллийн санг ашиглалтад оруулж эрүүл ахуй, чанарын хяналтаа зохих хэмжээгээр сайжруулсан зэрэг хүнсний тогтолцоонд зохих ахиц дэвшил гарсан.

Гэсэн хэдий ч, хүн амын хүнсний хэрэгцээний чухал хэрэгцээт хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлт импортоос хамааралтай байна. Монгол хүний хүнсний хэрэглээнд мах, гурилан бүтээгдэхүүн зонхилж, эрдэс амин дэмийн гол эх үүсвэр болдог жимс, жимсгэнэ, нарийн ногоо бага байгаа нь бичил тэжээлийн дутал, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийн дунд аминдэм, эрдсийн дутлын тархалт өндөр байх шалтгаан болж байна. Үүнээс улбаалан хүн амын дундах илүүдэл жин, таргалалт, хорт хавдрын өвчлөл илт нэмэгдсэн байна.

Тиймээс энэхүү төсөл хэрэгжсэнээр хөдөө аж ахуйн өртгийн сүлжээний алдагдлыг бууруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн технологи, тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалтын түвшинг олон улсын өнөөгийн түвшинд хүргэж, тухайн салбарын оролцогч талуудын оролцоог бүрэн хангасан, байгаль орчинд ээлтэй хөгжлийн шинэ үеийг хөдөө аж ахуйн салбарт авчирна гэдэгт талууд бүрэн итгэлтэй байна.



ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ОРСОН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААР ТАНИЛЦУУЛАХ УУЛЗАЛТ, ЗӨВЛӨГӨӨНД ОРОЛЦЛОО

Монгол Улсын Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хурал шинэчлэн баталсан бөгөөд хууль 2021 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлнэ. Уг хууль хэрэгжиж эхэлснээр хөрөнгө оруулах, бизнес эрхлэх болон бусад зорилгоор Монгол Улсад зорчих гадаадын иргэд цахимаар виз мэдүүлэх, виз олголтыг цахимаар олгох, Монгол Улсад оршин суух хугацааг 3 хүртэлх жилээр олгох зэрэг уян хатан, нээлттэй болгосон эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Мөн гадаадын хөрөнгө оруулагчийн статусыг нэмэгдүүлж, виз мэдүүлэх, олгох, оршин суух зөвшөөрөл олгоход зориулсан таатай хуулийн заалтууд орсон байна. Энэ хүрээнд Гадаадын иргэн харьяатын газраас санаачлан Монгол Улсад суугаа гадаад улсын элчин сайдын яамд, тухайн орны хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчид болон иргэдийн нийгэмлэгтэй хамтран хууль таниулах, сурталчлах ажлыг үе шаттай

зохион байгуулж байна.

Одоогийн байдлаар БНХАУ, БНСУ, БНСВУ-уудын Элчин сайдын яамдуудтай уулзалт хийсэн бөгөөд үргэлжлүүлэн Япон улс, АНУ, ОХУ зэрэг элчин сайдын яамдуудтай уулзалт хийхээр төлөвлөж байна.

БНСУ-ын элчин сайдын яамтай хамтран Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар танилцуулах уулзалт, зөвлөгөөнд Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Н.Ууганбаяр, Үндэсний хөгжлийн газраас Хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Н.Дашдэмбэрэл, БНСУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны Нэгдүгээр нарийн бичгийн дарга Ким Тае Вон, Монгол Улсад оршин суугаа Солонгос иргэдийн нийгэмлэгийн захирал Пак Ху Сон болон тус улсаас Монгол Улсад оршин суугаа хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгч иргэдийн төлөөлөл оролцсон юм.

ГИХГын дарга Н.Ууганбаяр арга хэмжээг нээж хэлсэн үгэндээ Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт болон тус газрын үйл ажиллагаандаа нэвтрүүлж буй цахим үйлчилгээнүүд нь Монгол Улсад зорчих гадаадын иргэдэд виз мэдүүлэх таатай нөхцлийг бүрдүүлж, үйлчилгээ авахад илүү хялбар болж буйг онцлов.

Мөн тэрээр Монгол Улсад аялал жуулчлалын зорилгоор зорчиж буй гадаадын иргэдийн дунд эзлэх БНСУ-ын иргэдийн статистик тоон мэдээлэл болон шинээр олгож эхлэх цахим визийн үйлчилгээ, аялал жуулчлалыг дэмжин зорилгоор илүү олон жуулчин татах боломж, нөхцөлийг бүрдүүлэхээр ажиллаж байгаа талаар мэдээлэл өглөө.

Мөн энэ үеэр ҮХГын Хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Н.Дашдэмбэрэл "Монгол Улсын өнөөгийн эдийн засаг, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин" хууль тогтоомжтой холбоотой мэдээлэл өглөө.



ҮХГ-ААС “МОНГОЛ-ЯПОНЫ БИЗНЕС ФОРУМ”-ЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Цар тахлын улмаас олон улсад худалдаа, хөрөнгө оруулалтын урсгал буурсан ч Үндэсний хөгжлийн газар нь Монгол Улсын хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалт, сурталчилгааг хариуцах чиг үүргийнхээ хүрээнд Японы Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын байгууллага /JETRO/, Монгол Улсаас Япон улсад суугаа ЭСЯ, Олон Улсын Санхүүгийн Корпораци (IFC), Ирбис Венчурс компанитай хамтран “Invest in Mongolia - Tokyo 2021” Монгол-Японы бизнес форумыг 2021 оны 5 дугаар сарын 20-ны өдөр цахимаар зохион байгууллаа.



ЭНЭ ЖИЛИЙН ЦАХИМ ФОРУМЫН ОНЦЛОГ НЬ:

- Уул уурхайн бус бусад тэргүүлэх салбаруудаас (мэдээлэл технологи, органик бүтээгдэхүүн, ХАА, сэргээгдэх эрчим хүч гэх мэт) төсөл сонгон шалгаруулж, нэг сарын турш чадавхжуулан, сурталчилсан

- Хувийн хэвшлийн оролцоог илүү хангаж, өнгөрсөн 30 жилийн хөрөнгө оруулалтын ололт, бэрхшээлийг үүрсэн япон, монгол бизнесүүдийг сонгон хэлэлцүүлэг хийснээр

- Япон улсаас бодит хөрөнгө оруулалт татсан туршлагыг хуваалцсан

- Хөрөнгө оруулалтын орчин үүссэн хүндрэл бэрхшээлийг нээлттэй хэлэлцэж, шинэчлэн сайжруулах тал дээр хийгдэж байгаа цогц төлөвлөгөөг Үндэсний хөгжлийн газар танилцуулсан зэргээрээ онцлог байлаа.

Тухайлбал, Монгол Улсын томоохон хөрөнгө оруулагч Мобиком корпорацийн Ерөнхий захирал Тацуяа Хамада Монгол Улсад хэрхэн хөрөнгө оруулсан туршлагаасаа, Японы Марубени корпорациас 10.3 сая ам долларын хөрөнгө оруулалт татсан, технологийн дэвшилтэт шийдэл Fintech-ээр санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг Анд глобал компанийн гүйцэтгэх захирал Б.Хос-Эрдэнэ хөрөнгө оруулалт татсан амжилтын түүхээсээ, Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний салбарт хамгийн анхны хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар цахилгаан станцын бүтээн байгуулалтуудыг хийсэн Ньюком Группын ТУЗ-ийн гишүүн Э.Орчлон Япончуудын хамгийн их сонирхол татаж буй Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний салбарын ирээдүй, боломжуудын талаар хэлэлцлээ.

Монгол хонины арьсаар MONY RUGBY бөмбөгийг үйлдвэрлэж, Монгол малын арьсыг дэлхийд таниулж, Монголын аж үйлдвэрт нэмэр оруулах зорилготой Ямагүчи Сангёо ХХК, Монгол чацарганыг Япон Улсын зах зээлд танилцуулах зорилгоор чацарганын түүхий эдийг ашигласан "Made in Japan" гоо сайхны болон эрүүл мэндийн ГУАМАРАЛ брэндийг үүсгэж, үйл ажиллагаагаа эхлүүлсэн Япон Улсын "Такаражима Жапан" ХХК, мөн Сумитомо Корпорацийн амжилтын түүхээс хуваалцсан нь маш сонирхолтой байлаа.

Арга хэмжээний гол цөм болсон Төслийн танилцуулга хэсэгт - Start up World cup тэмцээнээс Монголоос оролцохоор шалгарсан, дуу яриаг бичвэрт, бичвэрийг дуу ярианд хөрвүүлэгч Chimege Systems, ХАА, Аквапоник тариалалт болон загас үржүүлгийн аж ахуй эрхлэгч Little River, нарны хавтан, салхин сэнс бүхий сэргээгдэх эрчим хүч ашиглан цахилгаан үүсгүүрийн хосолмол систем болж чадсан явуулын бичил "цахилгаан станц" Nomadic Powerbox, таны гарт багтах дижитал эмнэлэг - Clinica төсөл, Хараа заслын лэзик төв байгуулах Solongo Kharaa, хөдөө аж ахуй, газар тариалан, гоёлын цэцэг тариалалтын Urban Lily, ноос ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгч sustainable fashion - Zoson, Монгол сүү сүүн бүтээгдэхүүн бяслаг үйлдвэрлэгч, Монголын бяслагийн Японы зах зээлд гаргах сонирхолтой Mongolian Artisan Cheesemakers Union (MACU) компаниудын төслийн танилцуулгууд Японы хөрөнгө оруулагчдын анхаарлыг татаж байлаа.

Японы талаас Японы Эдийн засаг, худалдааны яам (METI) дэмжиж, Гадаад худалдааны байгууллага (JETRO) хамтран зохион байгуулсан бөгөөд Монголтой танилцаж, төслүүдийг сонирхон хамтран ажиллах зорилгоор Японы Sumitomo bank, Marubeni, Mitsui Bussan, Sojits, Nissan, Nikki global, Itochu, Sysmex corporation, MUFG, Mobicom, KDDI, Mitsubishi, Tokyo Electric tower зэрэг Японы томоохон корпораци, банк, санхүүгийн байгууллагын төлөөлөл оролцсон нь Японы бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчид Монголыг шинэ зах зээл, хөрөнгө оруулалтын шинэ талбар хэмээн үзэж байгааг илтгэж байна.

Монгол Японы бизнес форумд Японы талаас 340 гаруй, Монголын талаас 50 гаруй нийт 400 гаруй төлөөлөгч оролцохоор бүртгүүлсэн нь хэдий цар тахлын үе ч гэсэн хоёр талын сонирхол өндөр байгааг илэрхийлж байна. Японы талаас банк санхүү, барилга, хүнс, хөнгөн үйлдвэрлэл, бусад үйлдвэрлэлийн салбарууд, тээвэр, худалдаа, боловсрол зэрэг салбаруудын төлөөлөл оролцлоо.

Хөрөнгө оруулалтын цахим буухиа цаашид 6 дугаар сард зохион байгуулагдах Сөүл-2021 форумаар үргэлжилнэ.

Арга хэмжээний дэлгэрэнгүй хөтөлбөр, панелист, илтгэгчдийн товч мэдээлэл, төслүүдийн товч танилцуулга болон "Invest in Mongolia" хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдэд зориулсан сар тутмын цахим сэтгүүлийг монгол, япон, англи хэлээр ҮХГ-ын www.japan.investmongolia.gov.mn -ээс үзнэ үү.



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛҮҮДЭЭ БЭЛТГЭЖ БАЙНА

Олон улсаас хөрөнгө оруулалт татах сонирхолтой, тодорхой төсөлтэй үндэсний үйлдвэрлэгч, аж ахуйн нэгж, компани, стартапуудад зориулж төслөө чадавхижуулж, сайжруулахад нь дэмжих, цаашилбал, хөрөнгө оруулагчтай нь холбож өгөх зорилгоор “Төсөл чадавхижуулах хөтөлбөр”-ийг Үндэсний хөгжлийн газраас санаачлан, Ирбис Венчурс, Жи-Эм-Жи Консалтинг компанитай хамтран зарлаж, шалгаруулалтын үйл ажиллагаа амжилттай болж дууслаа.

2021 оны 4 дүгээр сарын 19-нд аялал жуулчлал, ХАА, газар тариалан, эрүүл мэнд, мэдээллийн технологи, барилга, хүнсний үйлдвэрлэл, гоёл, хувцас загвар, худалдаа, маркетинг, финтек, сэргээгдэх эрчим хүч зэрэг салбаруудын 46 төслийг Ирбис Венчурс компанийн зохион бүтээсэн “Irbis Oasis” цахим платформоор хүлээн авсан бөгөөд 4 дүгээр сарын 20-ны өдөр эхний шатны шалгаруулалтыг Үндэсний хөгжлийн газар, Ирбис Венчурс компанийн хамтарсан шүүгчдийн бүрэлдэхүүн хийж, 12 төслийг сонгон шалгаруулсан. 4 сарын 21-ний өдөр “Төсөл чадавхижуулах хөтөлбөр”-ийн эцсийн шатны шалгаруулалтыг төр, хувийн хэвшлийн 14 төлөөллөөс бүрдсэн хараат бус шүүх бүрэлдэхүүнд эхний шатнаас шалгарсан 11 төсөлтэй (нэг төсөл өөрийн саналаар татгалзсан) танилцаж, тодорхой асуултуудыг асууж, зөвлөгөө зөвлөмж өгч, таван төслийг цахимаар шалгарууллаа. Уг шалгарсан таван төслийг дурдвал.

- **ЧИМЭГЭ СИСТЕМС** /Программ хангамж, Voice tech, AI, NLP/
- **ZOSON FASHION** /Хөнгөн үйлдвэрлэл/
- **“МОНГОЛИАН АРТИЗАН ЧИЙЗМЭЙКЕРС ЮНИОН” ХХК** /Хөдөө аж ахуй/
- **“НОМАДИК ПАУЭРБОКС”** /Сэргээгдэх эрчим хүч /

Эцсийн шатанд шалгарсан төслүүдийг нэг сарын хугацаанд “Төсөл чадавхижуулах хөтөлбөр”-т хамруулж, дотоод болон гадаадын хөрөнгө оруулагч, мэргэжилтнүүдээс хөрөнгө оруулалт татахад төслийн тооцоолол, давуу тал, онцлогийг тодруулж, хөрөнгө оруулагчдад танилцуулах, хөрөнгө оруулагчдыг төсөлдөө татан оролцуулах, хөрөнгө оруулагчтайгаа таатай, итгэлцэл бүхий харилцааг үүсгэх, цаашид хамтран ажиллах зэрэг арга барилд сургаж чадавхижуулсан юм.


Бусад төсөл хөтөлбөрүүдийн адил ямар нэгэн санхүүгийн дэмжлэг үзүүлэхгүйгээр, шалгаруулалтад тэнцсэн төслүүдийг дотоодын болон олон улсын хөрөнгө оруулагч, менторуудаас үнэ цэнтэй зөвлөгөө, зөвлөмж авч сайжруулан, олон улсын тавцанд гарахад нь дэмжлэг үзүүлж, Үндэсний хөгжлийн газраас 5, 6 дугаар сард Япон, БНСУ-ын хөрөнгө оруулагчдад танилцуулах боломжийг олгож дэмжиж ажиллана.

Төрөөс зөвхөн томоохон мега төслүүдийг дэмжихгүйгээр ЖДҮ, стартапуудыг мөн адил дэмжиж, зөвхөн уул уурхайн салбараас хараат байхаас зайлсхийж, эдийн засгийг солонгоруулах

чиг хандлага руу төр болон хувийн хэвшил илүүтэйгээр анхаарч, аж ахуйн нэгжүүдийг дэмжих “Төсөл чадавхижуулах хөтөлбөр”-ийн төслийн шалгаруулалтын үйл ажиллагааг <https://oasis.irbis.sg/> платформоор хүлээн авч, цахимаар хоёр шатны шүүлтийг нээлттэй, ил, тод шударгаар зохион байгуулсан нь шинэлэг, онцлог боллоо.

ЭХНИЙ ШАТНЫ ШАЛГАРУУЛАЛТ 4/20

- УХГ-ын 4 шүүгч, Ирбис Венчурс, Жи-Эм-Жи компанийн 4 шүүгч
- Нийт 46 төслөөс 12 төсөл шалгарсан
- ЭЦСИЙН ШАТНЫ ШАЛГАРУУЛАЛТ 4/21
- Төр, хувийн хэвшлийн 14 төлөөллөөс бүрдсэн хараат бус шүүх бүрэлдэхүүн цахимаар төслүүдтэй танилцаж шүүсэн
- 11 төслөөс 5 төсөл шалгарсан
- ТӨСӨЛ ЧАДАВХИЖУУЛАХ ХӨТӨЛБӨР 4/22-5/20
- Ирбис Венчурс, Жи-Эм-Жи компанийн боловсруулсан төсөл чадавхижуулах хөтөлбөрт 5 төсөл хамрагдаж байна.
- 6/23-нд “Invest in Mongolia Seoul-2021” Монгол – Солонгосын бизнес форумд 4 төслүүдийг танилцуулна.



ЧИМЭГЭ

Чимэгэ нь бол монгол, казах, киргиз зэрэг алтайн язгуурын хэлээр эхэлж буй бага нөөцтэй хэлний яриаг автоматаар таних, бичвэрийг ярианд хөрвүүлдэг анхны технологи юм.

Чимэгэ технологийг бүтээгчид нь яриаг автоматаар бичвэрт буулгадаг болон бичвэрийг ярианд хөрвүүлдэг аппликейшн, түүнчлэн API бүтээгдэхүүнүүдээ зах зээлд гаргасан бөгөөд эдгээр нь олон салбарт бизнесээ оновчтой болгоход хэрэглэгдэж, түүнчлэн хувийн хэрэглэгчдийг ая тухтай байлгах боломжийг олгожээ. Виртуал туслах, дуут удирдлагатай роботууд зэрэг өнөөгийн болон ирээдүйн дэвшилтэт системүүдийн суурь болох энэхүү технологийн шийдэл нь улам бүр бидний амьдралын салшгүй хэсэг болж, бүхий л салбарт хэрэглэгдэх хязгааргүй боломжтой юм. Бид хүмүүсийн төрөлх хэлээр ярих чадвартай хиймэл оюун ухааныг бүтээж тэднийг орчин үеийн технологитой холбохыг зорьж байна.

Чимэгэ системс нь гүн мэдрэлийн сүлжээг ашиглан яриаг автомат таних (ASR) болон бичвэрийг ярианд хөрвүүлдэг системийг Монгол хэлний хувьд 97% нарийвчлалтай анхлан боловсруулсан бөгөөд энэ нь Гүүгл компанийн 2017 онд зарласан Англи хэлний яриа таних нарийвлэлийг анхлан 95% хүргэсэнтэй харьцуулахад давсан амжилт юм.

Wr Chimege
Writer

Ke Chimege
Keyboard

Tt Tungaamal
Toli

Re Chimege
Reader

Mv Mongol
Voice

Vg Voice
Games

ВЕБ: www.chimege.mn
ФЭЙСБҮҮК: [chimegesystems](https://www.facebook.com/chimegesystems)
УТАС: 77111140

Э-МЭЙЛ: info@chimege.mn
ТВИТТЕР: [chimegesystems](https://twitter.com/chimegesystems)



ХӨНГӨН ҮЙЛДВЭРЛЭЛ

/SUSTAINABLE FASHION/

Манай компанийн гол уриа нь brings sustainability буюу байгальд ээлтэй брэнд болох бөгөөд ноолуурын үйлдвэрүүдийн хаягдлыг хямд үнээр худалдан авч бүтээгдэхүүн хөгжүүлэлт хийж байгаа нь олон улсад брэндийн чиг хандлага sustainable fashion болсонтой мөн холбоотой.

- Ноос ноолуурын хувьд түүхий эдийн гарал үүсэл, түүнийг бэлтгэх эко систем

нь үйлдвэрлэгчдийн хувьд сорилт болж байгаа бөгөөд бидний хувьд их хэмжээгээр үйлдвэрлэх бус, хариуцлагатайгаар үйлдвэрлэх зорилго тавьдаг.

- Компанийн үйлдвэрлэлийн 10%-ийг ноолууран бүтээгдэхүүн эзэлдэг ба бид Улаанбаатарт үйл ажиллагаа явуулдаг ноолуурын үйлдвэрүүдийн эсгүүрийн хаягдлыг дахин ашиглах замаар шинээр

бүтээгдэхүүн хөгжүүлэлт хийдэг.

- Төслийн хүрээнд энэ үйлдвэрлэлээ 40%-д хүргэх, байгальд ээлтэй ноолууран (Sustainable cashmere) бүтээгдэхүүний брэнд үүсгэх гол зорилготой. Мөн төслийн хүрээнд зөвхөн ноолуур бус дэлхийд ховорт тооцогддог түүхий эд болох сарлагийн хөөвөр, тэмээний ноосны эко системийг бий болгож, үйлдвэрлэгч болох төлөвлөгөөтэй.

SUSTAINABLE CASHMERE
Z O S O N
A source from upcycled fabrics

“МОНГОЛИАН АРТИЗАН ЧИЙЗМЭЙКЕРС ЮНИОН”

Монголын бяслаг урлаачдын холбоо / MACU/ нь Монголын алслагдмал бүс нутагт уламжлалт нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг нутгийн иргэдтэй хамтран сүү сүүн бүтээгдэхүүнийг гар аргаар боловсруулах бяслагны үйлдвэрүүдийг барьж байгуулан дэлхийн зах зээлд Монгол бяслагыг урлагын түвшинд гаргахаар зорьж байгаа билээ.

MACU нь нийгэм болон хүрээлэн буй орчныг хамгаалах, Монголын нүүдлийн уламжлалт аж ахуйг хадгалах, нөхөн сэргээх, малчидын амьжиргааг дээшлүүлэн хөгжүүлэхэд анхаарч байна

МХААИС-н дэргэдэх Байгалийн нөөц ба Хөдөө аж ахуйн эдийн засгийн хүрээлэнтэй хамтран орон нутгийн иргэдийн оролцоотойгоор өндөр


төвшиний бяслагны үйлдвэр байгуулан, түүнд тулгуурлан бичил хөдөө аж ахуйн цогц бүтэц бүхий мастер төлөвлөгөөг боловсруулж байна. Мөн аж ахуйн нэгж үйлдвэр бүрт зориулсан байгууллагын менежментийн системийг боловсруулж, бяслаг урлаачдын хийсэн бяслагыг зөөвөрлөн, зарж, сурталчлан борлуулах нэгдсэн удирдлагын сүлжээг бий болгож байна.

“MACU” нь Монголын болон гадаадын хөрөнгө оруулагчтай компани юм.

Э-мэйл: michaeldavidmorrow@gmail.com

Утас: +976 95177843,

Веб: www.macu.mn



СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ, ЭРЧИМ ХҮЧНИЙ ХАДГАЛАЛТ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ТАВААРЫН ХУДАЛДАА

- Бид 2020 оны 5 сард Номадик Пауэрбокс компаниа үүсгэн байгуулсан. Манай компани алслагдмал, төвийн шугамаас хол нутгуудад амьдарч, ажиллаж буй хүмүүсийн эрчим хүч, эдийн засгийн суурь бүтцийн асуудлуудаас улбаалан гарсан ядуурлын түвшинг бууруулах зорилготой ажиллаж байна.
- Пауэрбокс нь нарны хавтан, салхин сэнс бүхий сэргээгдэх эрчим хүч ашигласан цахилгаан үүсгүүрийн хосолмол систем болж чадсан явуулын бичил “цахилгаан станц” юм. Явуулын байхаар шийдсэн нь манай улсын онцлогт нийцсэн төдийгүй ёс заншилтайгаа ч холбогдоно.
- Үйлдвэрлэсэн илүүдэл цахилгааныг батерейнд нөөцөлж болно эсвэл төвийн сүлжээнд нийлүүлэх боломжтой.
- Пауэрбоксыг бүтээхдээ бид програм хангамж, техник хангамж аль алиныг нь хослуулсан. Техник хангамж талаасаа угсарах, зөөвөрлөхөд маш хялбар. Програм хангамжийн хувьд бүхээгт машин болон чингэлгийн хувилбаруудыг аль алныг нь өөрсдийн бүтээх эрчим хүч / хөдөө аж ахуйн цахим бирж / платформтойгоо холбох төлөвлөгөөтэй байгаа.
- Улмаар тариаланчид, фермерийн аж ахуй эрхлэгчид өөрсдийн дундын ченж наргүйгээр бүтээгдэхүүнүүдээ зах зээлд шууд нийлүүлэх боломжтой болно.

Танилцуулга: <https://www.youtube.com/watch?v=TGyH9oeCtgw>

Facebook: [nomadicpowerbox](https://www.facebook.com/nomadicpowerbox)

LinkedIn: <https://mn.linkedin.com/company/nomadic-power-box>



ҮХГ болон ОУСК-ийн төлөөлөгчдийн баг Сөүл хотноо KOTRA-ийн оффис дээр, 2018 оны 11-р сар.

ОУСК-ААС МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАРТ ҮЗҮҮЛСЭН ТЕХНИКИЙН ТУСЛАЛЦААНЫ ХҮРЭЭНД БНСУ-ЫН ЖИШГИЙГ АШИГЛАН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ МЕХАНИЗМЫГ НЭВТРҮҮЛСЭН НЬ.

Хөрөнгө оруулалтын оновчтой бодлого, хамгаалалтын механизмыг бий болгоход Монгол Улсын Засгийн газарт дэмжлэг үзүүлэх үүднээс ОУСК нь Хөрөнгө оруулалтын бодлого, хөдөө аж ахуйн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийг 2013 оноос хойш хэрэгжүүлж ирсэн.

ОУСК-аас 2013-2014 онд 70 аж ахуйн нэгжүүдийг хамруулан хийсэн хөрөнгө оруулагчдын гомдол, тэдгээрийн үр дагаврын талаарх судалгаагаар дараах үр дүнг тогтоосон. Үүнд:

- Судалгаанд хамрагдсан компаниудын 75 хувь нь хөрөнгө оруулагчийг хамгаалах асуудал нь томоохон хүндрэл болдог гэж үзсэн байна;
- Хөрөнгө оруулагчийн хулиар олгогдсон эрх ашгийг хөндсөн асуудалтай холбоотой гомдлууд нь хөрөнгө оруулалтанд сөргөөр нөлөөлж буйг судалгаанд хамрагдсан компаниуд олонтаа дурьдсан байдаг. Судалгаанд хамрагдсан компаниудын 4/5 нь хөрөнгө оруулагчийн хамгаалалын асуудал хангагдахгүй байгаа улмаас тэдгээрийн оруулсан хөрөнгө оруулалт тус орноос буцаан татагдах эрсдэлд хүрч болзошгүй гэж үзэж байна. Хөрөнгө оруулагчийг хамгаалах орчин хангалтгүйн улмаас алдагдал хүлээж болзошгүй эрсдэл бүхий нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 1.9 тэрбум ам.доллар буюу хөрөнгө оруулалтын нийт дүнгийн 90 хувьтай тэнцүү байхаар тооцоо гарсан байна;
- Хөрөнгө оруулагчдын үзэж байгаагаар бодлого, зохицуулалтын ил тод бус байдал болон төрийн байгууллагуудын асуудалд үзэмжээрээ хандах, дур мэдэн шийдвэр гаргах байдал нь гомдол гаргах гол нөлөө бүхий хүчин зүйл болж байна. Түүнчлэн



Creating Markets, Creating Opportunities

хөрөнгө оруулагчийн өмч хөрөнгийг хураах, эрхийг түдгэлзүүлэх (судалгаанд оролцогчдын 45%), ялгаварлан гадуурхах (судалгаанд оролцогчдын 24%) байдлыг томоохон хүндрэлүүдийн нэг гэж үзсэн байна;

- Судалгаанд хамрагдсан компаниуд хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдэж буй өнөөгийн арга зам, нөхцөл байдалд сэтгэл хангалуун бус байгаагаа илэрхийлсэн байдаг. Төрийн байгууллагуудын зүгээс гомдол саналын дагуу хариу арга хэмжээ авч буй, асуудлыг шуурхай шийдвэрлэж буй, гаргасан шийдвэрийн нийцтэй байдал зэргийг ярилцлаганд хамрагдсан бизнес эрхлэгчдийн 55 хувь нь "хангалтгүй" болон "туйлын хангалтгүй" гэж үнэлсэн байна;
 - Төрийн байгууллагуудын зүгээс өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн байдал мөн хангалтгүй гэж үнэлэгдсэн байна. Бизнес эрхлэгчид гомдлоо шийдвэрлүүлэхэд ямар арга зам ашигласнаас үл хамааран судалгаанд хамрагдсан компаниудын бараг хагас нь холбогдох гомдол саналаа огт шийдвэрлүүлж чадаагүй гэсэн бол дөнгөж 6 хувь нь нийт гомдлынхоо 80-100 хувийг шийдвэрлүүлсэн гэж хариулжээ.
- Судалгааны дүнгээс харахад хөрөнгө оруулагчийн гомдолтой холбоотой асуудлыг шийдвэрлэж буй өнөөгийн арга механизм үр дүн муутай байгаагаас гадна төрийн байгууллагуудын зүгээс хөрөнгө оруулагчийн хулиар олгогдсон эрхийг хамгаалахтай холбоотой гомдлыг албан ёсны шүүхийн маргаан болж даамжрахаас өмнө олж илрүүлэх, түүнд хяналт тавих, шуурхай шийдвэрлэх механизм дутмаг байгааг харуулж байна. Хөрөнгө оруулагчидтай хийсэн ярилцлагаас харах хөрөнгө оруулагчийн хамгаалалтай холбоотой гомдлууд нь гол төлөв дараах хүчин зүйлсийн улмаас үүсч байна. Үүнд:

1. УИХ-аас хууль батлахдаа зохих үйл явцыг дагаж мөрдөггүй;
2. Засгийн газар болон орон нутгийн түвшний агентлагуудын зүгээс гаргаж буй шийдвэр, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь хөрөнгө оруулалтын тухай Монгол Улсын хууль болон тус орны нэгдэн орсон Хөрөнгө Оруулалтын Олон Улсын Гэрээ Хэлэлцээр (ХООУГХ)-тэй хэрхэн уялдаж байгаа, таагүй үр нөлөө үзүүлж болзошгүй талаарх мэдлэг ойлголт дутмаг;
3. төрийн байгууллага, агентлаг хоорондын харилцаа холбоо, мэдээлэл солилцоо хангалтгүй; мөн
4. Монгол Улсын дотоодын хууль тогтоомж, хөрөнгө оруулалтын олон улсын гэрээ хэлэлцээрийн хүрээнд хүлээсэн үүргийн хэрэгжилт хангалтгүй байгаа зэрэг болно.

ОУСК-ын зүгээс хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах, улмаар итгэлийг сэргээхэд түлхэц үзүүлэх үүднээс хөрөнгө оруулагчдын гомдлыг хүлээн авах, шийдвэрлэлтийн үйл явцыг мөшгөн хянахад чиглэсэн Хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх механизм (ХОГШМ)-ыг нэвтрүүлэхийг Засгийн газарт санал болгосон болно.

Засгийн газар дээр дурьдсан судалгааны зөвлөмж болон ҮХГ-тай хамтран хийсэн хөрөнгө оруулалтын орчин, бодлогын цогц оношилгоо болох Хөрөнгө оруулалтын бодлогын шинэчлэлийн зураглал судалгааны тайлан (2018 оны 6-р сар)-д үндэслэн Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийг байгуулж (2016 оны 12-р сар), нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлж (2019 оны 2-р сар), ХОГШМ-ын журмыг баталж (2019 оны 3-р сар), улмаар ХОГШМ-ын МТ-ийн системийг ашиглалтад оруулж (2020 оны 6-р сар), түүний үйл ажиллагааг сайжруулах ажил хэрэгжүүлж эхэлсэн.

БНСУ-ын Омбудсман, мөн КОТРА (Худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих агентлаг)-ийн хөрөнгө оруулалтын дараах үйлчилгээний туршлага нь ХОГШМ-ыг Монголд нэвтрүүлэхэд урам зориг өгч, илүү баяжуулах үндэс болсон юм. ОУСК нь 2016 онд Монгол Улсын Хөрөнгө оруулалтын газар болон БНСУ-ын Омбудсманы төлөөлөгчдийн хооронд цахим уулзалтууд зохион байгуулж, 2018 оны 11-р сард БНСУ-д гурван өдрийн танилцах аялал мөн зохион байгуулсан. Хөрөнгө оруулагчдад дэмжлэг үзүүлэх, тэдгээрийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах талаар Солонгосын агентлагуудын хуримтлуулсан туршлага нь Монголын Засгийн газрын төлөөлөгчдөд ихээхэн түлхэц үзүүлж, нэг цэгийн үйлчилгээний төв болон ХОГШМ-ыг нэвтрүүлэх алсын харааг тодорхой болгоход нөлөөлсөн.



ОУСК-ийн Макро эдийн засаг, Худалдаа, Хөрөнгө оруулалтын газрын Хөрөнгө оруулалтын бодлогын төслийн удирдагч Д. Жигжидмаа.

ХОГШМ болон түүний цахим платформыг хөгжүүлэх хоёр жилийн хугацаанд Засгийн газар дараах зүйлсийг удирдлага болгосон. Үүнд:

1. Солонгост үйл ажиллагаа явуулж буй гадаадын хөрөнгө оруулалттай компаниудаас гаргасан гомдлыг шийдвэрлэх нь гадаадын хөрөнгө оруулагчдын сэтгэл ханамж болон дахин хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх тул гомдлыг тийнхүү шийдвэрлэх нь ГШХО-ыг дэмжих үндсэн стратеги болно;
2. Хоум доктор (Home Doctors)-ын түвшинээс Гадаадын хөрөнгө оруулалтын хороо хүртэл гомдлыг тодорхой шатлалтай шийдвэрлэх үе шатууд байдаг;
3. Гадаадын хөрөнгө оруулагчдыг дэмжих алба нь татвар, хөнгөлөлт урамшуулал, виз, газар төлөвлөлт, хөдөлмөр эрхлэлт, суурьших дэмжлэг (жолооны үнэмлэх авах г.м) зэрэг олон чиглэлээр зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий КОТРА-ийн нэг цэгийн үйлчилгээ (НЦҮ)-ний төв юм. Тус төвд хөрөнгө оруулагчид болон тэдний гэр бүлийн гишүүдэд нэг дор түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй ажилтнууд яам бүрээс ажилладаг. Жишээлбэл, Хууль зүйн яамны ажилтнууд гадаадын хөрөнгө оруулагчдад нэг цагийн дотор виз авахад тусалдаг бол ердийн үед виз авахад 3 сар хүртэл хугацаа шаардагддаг байна;
4. Засгийн газрын бодлого, институцийн нээлттэй бөгөөд тогтвортой байдал нь Солонгосын хөгжлийн гайхамшгийн гол амжилтын хүчин зүйл юм;
5. КОТРА болон Инвест Кореа нь Хөрөнгө оруулалтын тухай хууль болон Омбудсманы үйл ажиллагааг нарийвчлан тусгасан журам зэрэг

эрх зүйн баримт бичигт үндэслэн үйл ажиллагаагаа явуулдаг. Жишээлбэл, Омбудсманы ажлын албыг хэрхэн зохион байгуулах, гомдлыг хэрхэн шийдвэрлэх, хэрэг хэрхэн хянах үйл явц, мөн гомдлыг хянан шийдвэрлэхэд мэдээллийг нууцлах үүрэг зэргийг тус хуульд тодорхой заасан байдаг.

ҮХГ нь өнөөгийн байдлаар хэд хэдэн гомдлыг шийдвэрлэж, буцаан татагдах эрсдэлд ороод байсан 3.2 сая орчим ам.долларын хөрөнгө оруулалтыг хадгалан үлдээж чадсан бөгөөд дээрх тоо цаашид ч өсөх хандлагатай байна. ХОГШМ-ын цахим платформыг хөрөнгө оруулагчдын зүгээс түлхүү ашиглахад дэмжлэг үзүүлэх, түүнчлэн хөрөнгө оруулагчдын санаа бодлыг ойлгох, тэдний итгэлийг нэмэгдүүлэх, тэдгээрийн санал хүсэлтэд үндэслэн хөрөнгө оруулагч болон бизнес эрхлэгчдэд ээлтэй хөрөнгө оруулалтын орчныг бүрдүүлэх үүднээс төр-хувийн хэвшлийн үр дүнтэй яриа хэлцэл (диалог)-ийн платформыг бэхжүүлэн тогтмолжуулах чиглэлээр шаргуу ажиллах шаардлагатай байна. Түүнчлэн, хөрөнгө оруулагчдын баталгаа болон хамгаалалттай холбоотой Монгол Улсын хүлээсэн дотоодын болон олон улсын үүргийг ойлгож, хэрэгжүүлэх ур чадвар, чадавхийг Засгийн газар болон орон нутгийн удирдлагын түвшинд ажилладаг албан тушаалтнуудын дунд бэхжүүлэх шаардлагатай байна.



*Creating Markets,
Creating Opportunities*

Kotra

Korea Trade-Investment
Promotion Agency



Энэ удаагийн ярилцлагын буландаа “Котра Улаанбаатар” БНСУ-ын Гадаад худалдаа, төлөөлөгчийн газрын дарга ноён Жонг Вон Жүнийг урин БНСУ-ын хөрөнгө оруулалт татсан замнал, Ковид-19 цар тахалын эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээ болон хоёр орны худалдаа, хөрөнгө оруулалт, бизнесийн салбарын өнөөгийн байдлын талаар ярилцлаа

Юуны өмнө бидний саналыг хүлээн авч, цаг зав гарган ярилцлага өгч буй танд талархал илрэхийлээ. Засгийн газрын тохируулагч агентлаг УХГ-аас сар бүр эрхлэн гаргадаг “Invest in Mongolia” сэтгүүлийн нийт уншигчдад өөрийгөө болон байгууллагынхаа чиг үүргийн талаар товчхон танилцуулна уу?

Сайн байна уу? Котра Улаанбаатар буюу БНСУ-ын ГХТГ-ын дарга Жонг Вон Жүн байна. Юуны өмнө байгууллагынхаа талаар товч танилцуулбал, КОТРА нь дэлхийн 84 улсад 126 салбартайгаар үйл ажиллагаа явуулж буй БНСУ-ын Гадаад худалдаа хөрөнгө оруулалтын төрийн агентлаг бөгөөд 2013 оны 7-р сард Монгол улсын Улаанбаатар хотод 120 дахь салбар болох Котра Улаанбаатар Гадаад худалдаа төлөөлөгчийн газрыг /ГХТГ/ нээн ажиллуулсан юм.

Манай Котра Улаанбаатар ГХТГ-ын үйл ажиллагааны гол чиглэл нь хоёр улсын эдийн засаг, бизнесийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, худалдаа-хөрөнгө оруулалтыг дэмжих, дотоодын компани аж ахуйн нэгжүүдэд гадаад зах зээл дэх маркетингийн дэмжлэг үзүүлэх зэрэг болно. Үүнээс гадна KSP буюу мэдлэг хуваалцах хөтөлбөр, CSR буюу компаний нийгмийн хариуцлагын үйл ажиллагаа зэрэг бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд нэмэр болохуйц олон төрлийн үйл ажиллагааг явуулж байна.

Миний бие 2018 оны 8-р сард Котра Улаанбаатар ГХТГ-ын гурав дахь даргаар

томилогдон ажиллаж эхэлсэн бөгөөд Монгол улсад ирж ажилласнаар хоёр орны бизнесийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд бага ч гэсэн хувь нэмэр оруулах болсондоо маш их баяртай байгаа. Нэн ялангуяа өнгөрсөн жилээс ковид19 цар тахал дэгдсэнээр тал бүрийн үйл ажиллагаа хязгаарлагдсан хэдий ч цахим үзэсгэлэн, цахим уулзалтуудыг зохион байгуулан алсын зайны маркетингийн аргаар хоёр улсын бизнес эрхлэгчдийг холбох үүргийг амжилттай гүйцэтгэж ирснээ хувьдаа олзуурхаж байгаа.

Та Монгол Улсад томилогдон ирээд 3 жилийн хугацааг үджээ. Монголын соёл, зан заншилтай танилцах чөлөөт цаг, зав хэр их гардаг вэ? Та аль аймагт очиж, ямар төсөл дээр ажиллаж байсан талаар?

Гадаад улс дахь төлөөлөгчийн газарт томилогдон ажиллах томилолтын хугацаа гурван жил байдаг учраас миний хувьд ирэх 8-р сард Солонгос дахь төв рүүгээ буцаж болсон байгаа. Монголд ажиллах хугацаандаа эх орноосоо тэс өөр байгальтай Монгол орны өргөн уудам тал нутаг, одод түгсэн шөнийн тэнгэр зэргийг хараад багдах сэтгэл төрж байсан. Миний хувьд Улаанбаатар хоттой хамгийн ойр байрлах аялал зугаалгын бүс Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт олон удаа очиж үзсэн бөгөөд очих болгонд цаг улирлаа даган өөрчлөгдөх үзэсгэлэнт байгаль нь хамгийн ихээр сэтгэлд хоногшсон санагдана.

Мөн байгалийн үзэсгэлэнт цэнгэг уст нуур Хөвсгөл нуур болон хүн төрөлхтний соёлын өв хадгалагдсан говийн өргөн уудам газар нутаг нь Монгол Улс нь байгаль, соёлын аялал жуулчлалын арвин нөөц бололцоотойг харуулж байгаа санагддаг. Солонгост буцаж очоод ч Монголын байгалийн үзэсгэлэнт дурсан санах байхаа.

Таны ажлын туршлагыг сонсоход гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын чиглэлээр нилээдгүй олон жил ажилласан юм байна лээ. Та бидэнд БНСУ-ын гадаадын хөрөнгө оруулалтыг амжилттай татсан туршлага, замналын талаар хуваалцахгүй юу?

КОТРА-д ажилд ороод анхны гадаад улсад томилогдон ажилласан газар маань Вьетнам улсын Ханой хот байсан юм. Түүний дараа АНУ Нью Йорк хот, Италийн Милано хотуудад томилогдон ажиллаж байсан ба Монгол улс миний хувьд 4 дэх улс юм. АНУ болон Итали улсад Солонгос уруу хөрөнгө оруулалт татах

чиг үүргийг ихэвчлэн гүйцэтгэж байсан бол Вьетнамд Солонгосоос Вьетнам уруу чиглэсэн хөрөнгө оруулалт хийхэд дэмжлэг үзүүлж ажиллаж байсан.

Миний хувийн туршлагаас дүгнэхэд Вьетнам болон Монгол Улс нь гадаадын хөрөнгө оруулалтыг татах тал дээр маш олон зүйлүүдийг харьцуулж үзэж болохоор харагддаг. Үнэндээ Вьетнам болон Монгол нь хөрөнгө оруулалтын орчин нөхцөлийн хувьд маш өөр улсууд юм. Жишээ нь Вьетнам улс далайд гарцтай, хямд ажиллах хүчинтэй улс буюу үйлдвэрлэл эрхлэгчдэд таатай орчин нөхцөлтэй учраас Солонгосын үйлдвэрлэл эрхлэгчид илүү түлхүү хөрөнгө оруулдаг. Харин Монгол Улс нь далайд гарцгүйн дээр хөдөлмөрийн хөлс өндөр талдаа байдаг нь Солонгосын үйлдвэрлэл эрхлэгчид хөрөнгө оруулалт хийхэд таатай бус байдаг.

Монгол Улс нь иймэрхүү газар зүйн онцлог болон аж үйлдвэрийн бүтцээ харгалзан, үйлдвэрлэлийн салбараас илүү үйлчилгээний салбарт хөрөнгө оруулалт татах тал дээр түлхүү анхаарах хэрэгтэй болов уу гэж боддог. Түүнчлэн Монгол Улс нь бодлогоор дэмжин хөрөнгө оруулалт татах шаардлагатай үйлдвэрлэл болон боловсруулах салбарынхаа талаар баримтлах хэтийн стратеги төлөвлөгөөг гарган, хөрөнгө оруулалтын орчин нөхцөлийн давуу талыг сурталчлах байдлаар хөрөнгө оруулалт татах тал дээр анхаарч ажиллах ёстой болов уу гэж харж байна.

Дэлхий даяар цар тахлын нөлөөгөөр улс орнуудын гадаадын хөрөнгө оруулалт буурсан бөгөөд Солонгосын хувьд нөхцөл байдал хэрхэн нөлөөлсөн бэ? Мөн Солонгосын засгийн газрын зүгээс ямар хариу арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа вэ?

Солонгос Улс ч мөн адил цар тахлын нөлөөгөөр 2020 онд гадаадын хөрөнгө оруулалт мэдүүлсэн хэмжээгээр тооцсоноор 11.1 хувь буурч 20.7 тэрбум ам доллар, шилжиж орсон хэмжээгээр тооцсоноор 17 хувь буурч 11.9 тэр бум ам до лларт хүрсэн байна. Гэхдээ өнгөрсөн жилийн эхний хагаст цар тахлын улмаас огцом буурсан байдал нь сүүлийн хагаст огцом өссөнөөр, зургаан жил дараалан гадаадын хөрөнгө оруулалт 20 тэрбум ам доллар давсан амжилтыг үзүүлсэн болно.

Ийнхүү өнгөрсөн оны эхний хагаст буурсан

байдал сүүлийн хагаст огцом сэргэхэд засгийн газраас авч хэрэгжүүлсэн K-quarantine арга хэмжээ болон Солонгосын зах зээлийг сонирхож буй компаниудад зориулан цахим бизнес уулзалт, вебинар зэргийн алсын зайны маркетингийн сурталчилгааг бодлогоор хэрэгжүүлсэн нь үр дүнгээ өгсөн юм.

Мөн салбар тус бүрээр ирээдүйн шинэ аж үйлдвэр, шинэ технологийн үндсийг бүтээхийн төлөөх стратегийн хөрөнгө оруулалт татахад илүү анхаарсан юм. Ингэснээр аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгалын шинэ салбаруудад хөрөнгө оруулалт нэмэгдэж, шинэ технологи бүтээхэд шаардагдах тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, түүхий эдийн салбарт өсөлт гарсан бөгөөд нүүрсхүчлийн хийн ялгарлыг тэглэх зорилго бүхий ногоон хөгжлийн салбарт мөн хөрөнгө оруулалт нэмэгдэж ирээдүйн хөгжлийн суурийг бүтээхийн төлөөх хөрөнгө оруулалт нэмэгдсэн гэж хэлж болно.

Товчхондоо Котра нь Солонгос Улсынхаа компани аж ахуйн нэгжүүдийг гадаад зах зээлд гарахад дэмжлэг үзүүлдэг байгууллага. Тэгвэл Котра Улаанбаатар ГХТГ-аар дамжуулан Солонгосын бизнес эрхлэгчид манай улсын аль салбарт илүү хөрөнгө оруулах сонирхолтой байдаг вэ? Мөн тэдэнд тулгардаг саад бэрхшээл юу вэ?

Солонгосын талаас Монгол Улсад хөрөнгө оруулалт хийж эхэлсэн нь хоёр улс дипломат харилцаа тогтоосноос хойш буюу 1994 оноос эхэлсэн юм. Түүнээс хойш арван жилийн турш жилийн хэмжээнд дунджаар 1.8 сая ам доллар төдийхөн байснаа 2004 оноос огцом өсч 2008 онд 60 сая долларт хүрсэн байдаг.

2020 он хүртэлх Солонгосоос Монголд оруулсан хөрөнгө оруулалтын нийт хэмжээ 500 сая ам доллар бөгөөд салбар тус бүрээр авч үзвэл уул уурхайн салбар (27%) хамгийн их хувийг эзэлж байгаа бол түүний дараа бөөний болон жижиглэнгийн худалдаа (19%), үл хөдлөх (12%), барилга (11%) гэсэн салбаруудад голчлон хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Сүүлийн үед жижиглэн худалдаа болон эрүүл мэндийн салбарт хөрөнгө оруулалт өсөх хандлагатай байгаа.

Харин Монголд хөрөнгө оруулахад Солонгосын компаниудад тулгардаг саад бэрхшээлийн хувьд хөрөнгө оруулалт хийхийн өмнөх болон дараах гэж ялгаж үзэж болохоор байна. Монголд хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж буй компаниудын хувьд мэдээллийн дутмаг байдал гэж хэлж болно. Хөрөнгө оруулалт хийх хүсэл сонирхолтой боловч мэдээлэл олж авах арга замаа мэдэхгүй байх болон гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой хууль дүрэм англи хэл дээр байдаггүй талаар хөрөнгө оруулагчид гомдоллодог.

Харин Монгол Улсад хөрөнгө оруулсны

дараах саад бэрхшээлийн хувьд Солонгосын компаниуд голчлон төрийн үйлчилгээний ил тод бус байдал болон төрийн албан хаагчдын ойлгомжгүй үйлдэл, түүнээс гадна гадаадын хөрөнгө оруулалттай болон дотоодын компани гэж ялгах байдал нь саад бэрхшээл болдог хэмээн дурдсан байдаг.

Цар тахлын эсрэг Монгол Улсын засгийн газрын авч хэрэгжүүлж буй арга хэмжээг та юу гэж дүгнэж байгаа вэ?

Өнгөрсөн жилээс эхэлсэн ковид19 цар тахал бид бүхний өдөр тутмын амьдралын хэв маягийг маш ихээр өөрчиллөө. Монголын засгийн газар нь ковид19 тархалтын эхэн үеэс хилээ хаах зэрэг хатуу арга хэмжээ авч, дэлхийн дахинд үлгэр жишээ болохуйц байсан гэж би хувьдаа боддог. Солонгост ч Монгол улсын ковид19 цар тахлын эсрэг хэрэгжүүлсэн арга хэмжээг шилдэг хэмээн танилцуулсан удаатай.

Гэхдээ урьдчилан сэргийлэх тал дээр хэт анхаарсны улмаас эдийн засгийн идэвхийг сулруулсан нь харамсалтай тал бий. Монгол улсын засгийн газрын хувьд зайлшгүй шаардлагатай хариу арга хэмжээ байсан нь ойлгомжтой боловч бизнесийн байгууллагуудад дэмжлэг үзүүлдэг бидний зүгээс хоёр улсын хооронд зорчих асуудалд арай уян хатан хандаасай гэсэн хүсэлтэй байсан юм.

Өнгөрсөн жилийн хувьд урьдчилан сэргийлэх тал дээр голчлон анхаарч байсан бол энэ жилээс вакцинжуулалтыг эрчимжүүлж илүү идэвхтэй байдлаар цар тахалтай тэмцэж байгаа Монголын засгийн газрын бодлогыг өндрөөр үнэлүүштэй.

Вакцины эхний тунд хамрагдалтын түвшин аль хэдийн 90 хувийг давсан нь дэлхийд хамгийн өндөрт тооцогдож байгаа бөгөөд тун удахгүй хэвийн байдалд шилжих боломжтой гэж харж байна. Ингэснээр хоёр улсын хооронд зорчих урсгал хэвийн болж, бизнесийн зорилгоор ирж очих боломж нээлттэй болоосой хэмээн хүсч байна.

Таны хувьд Монголын бизнесийн орчныг хэрхэн дүгнэж байгаа болон сайжруулах тал дээр ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж, хөрөнгө оруулалт татах ямар бодлого баримтлах нь зүйтэй гэж үзэж байна вэ?

Хөрөнгө оруулагчийн байр суурьнаас дүгнэхэд Монголын бизнесийн орчин нь тийм ч таатай биш гэж харж байна. Юуны өмнө далайд гарцгүйгээс ачаа тээвэрлэлтийн хувьд таатай бус нөхцөлд байдгаас гадна цөөн хүн амтай байдал нь яагаад ч давуу тал болохгүй юм. Түүнчлэн хууль эрх зүйн тогтолцооны хувьд бусад ижил төстэй улсуудтай харьцуулахад харьцангуй давуу талтай биш учраас хөрөнгө оруулалт татахын тулд сайжруулах зүйл олон байгаа нь үнэн юм.

Иймд өөрийн орны харьцангуй давуу тал

болон хөрөнгө оруулагчдад олгох инсэнтив зэргийг тодорхой болгон гадаадын хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулах хүсэл сонирхол төрүүлэх, уриалах хэрэгтэй. Нэн түүнээс гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой хууль эрх зүйн орчныг олон улсын стандартад нийцүүлэн өөрчлөх хэрэгтэй болов уу. Холбогдох хууль дүрмүүдийг англи хэл дээр орчуулах зэргээр гадаадын хөрөнгө оруулагчдад мэдээллийн ил тод байдлыг хангаж өгөх хэрэгтэй. Мөн түүнчлэн төрийн үйлчилгээний ил тод байдлыг нэмэгдүүлж, гадаадын хөрөнгө оруулагчид бизнесээ явуулахад таатай нөхцөл бүрдүүлэх хэрэгтэй болов уу.

Дээр нь гадаадын хөрөнгө оруулагчдын санал гомдлыг хүлээн авч, шийдвэрлэдэг "ombudsman" системийг бодитоор хэрэгжүүлж хөрөнгө оруулагчдын санал гомдлыг шуурхай шийдвэрлэдэг тогтолцоог бий болговоос хөрөнгө оруулалт татахад дэмжлэг болох байх гэж бодож байна. Засгийн газрын төвшинд хөрөнгө оруулалт татах шаардлагатай стратегийн салбаруудад хөрөнгө оруулалтын төслүүдийг сонгон авч танилцуулга арга хэмжээ зохион байгуулах зэргээр илүү идэвхтэй хөрөнгө оруулалт татах арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Үндэсний хөгжлийн газар болон Котра гэсэн хоёр байгууллагын хамтын ажиллагаа илүү өргөжих болтугай хэмээн ерөөгөөд, цаг заваа гарган ярилцсан танд талархал илэрхийлье.

Тус тусын улсдаа гадаадын хөрөнгө оруулалт татах чиг үүргийг хариуцан ажилладаг Үндэсний хөгжлийн газар болон КОТРА нь өнгөрсөн хугацаанд хамтын ажиллагаагаа өргөжүүлэх зорилгоор "харилцан ойлголцлын санамж бичиг" байгуулан нягт хамтран ажиллаж ирсэн билээ.

Хойшдоо ч гадаадын хөрөнгө оруулалт татах асуудал төдийгүй төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх тал дээр хамтран ажилласнаар хоёр улсын эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх тал дээр илүү чухал үүрэг гүйцэтгэнэ гэж найдаж байна. Баярлалаа.



Хөрөнгө оруулалтын дэмжлэг, сурталчилгааны алба мэргэжилтэн
Ж.УРАНЗАЯА

МОНГОЛЫН ӨМГӨӨЛӨГЧДИЙН ХОЛБООНЫ ӨМГӨӨЛӨГЧ, ХУУЛЬЧ, “ӨМГӨӨЛЛИЙН ЭЛ БИ ПАРТНЕРС” ХХН-ИЙН ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ПАРТНЕР ӨМГӨӨЛӨГЧ БНСУ-ЫН ИРГЭН ЛИМ ТЭ СҮ-Г ОНЦЛОН ЯРИЛЦЛАА



Монголын Өмгөөлөгчдийн Холбооны өмгөөлөгч, хуульч, “Өмгөөллийн Эл Би Партнерс” ХХН-ийн үүсгэн байгуулагч, партнер өмгөөлөгч БНСУ-ын иргэн Лим Тэ Сүтэй уулзаж ярилцлаа. Тэрээр 1989 онд БНСУ-ын “Ханян” их сургуулийг цөмийн физикийн инженер мэргэжлээр төгссөн байна. 1991 оноос эхлэн Монгол Улсад 30 жил амьдарч, ажиллаж байна. Тэрбээр МУИС-ийн Хууль зүйн сургуульд суралцан төгсөж, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй цорын ганц гадаадын иргэн юм.

Та өөрийнхөө талаар товч танилцуулна уу?

Би 1991 оны аравдугаар сард анх Монгол Улсад ирж байлаа. Монголын түүх соёл, ёс, зан заншил, уламжлал нь Солонгос Улстай төстэй санагдсан учир энэ сонголтыг хийхэд нөлөөлсөн. Мэргэжлээрээ үргэлжлүүлэн суралцах зорилготой Монголд ирсэн боловч би монгол хэл мэдэхгүй учраас МУИС-ын монгол хэлний бэлтгэл курсэд жил гаруй суралцсан.



Та хэзээнээс эрх зүйч мэргэжлээр суралцсан бэ?

Монгол хэл сурсны дараа тухайн үеийн Багшийн дээд сургууль, одоогийн Боловсролын их сургуульд монгол соёл судлал, угсаатны зүйн чиглэлээр гурван жил сурсан. Энэ үед Солонгос хүмүүс Монголыг, Монголчууд Солонгосыг олноор зорих болж, хоёр орны иргэд бизнес хийж, хамтран ажиллах болсон. Би Монголд ажиллахаар ирсэн Солонгос хүмүүст орчуулга хийж өгдөг байлаа. Энэ үед Монгол Улсын хууль тогтоомжийг судалж мэдэх шаардлагатай юм байна, тэгвэл хүмүүст илүү тус болох юм байна гэж бодоод 2005 онд МУИС-ийн Хууль зүйн сургуульд элсэж суралцаад 2009 онд төгссөн. 1993 оноос 2003 он хүртэл Олон улсын Улаанбаатар их сургуульд солонгос хэлний багшаар ажилласан.

Сургуулиа төгсөөд 2011 онд хуульчийн сонгон шалгаруулалтад, дараа нь өмгөөлөгчийн мэргэшлийн шалгаруулалтад тус тус тэнцэж, Хууль зүй, дотоод хэргийн сайдаас өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан. Тодруулбал, гадаад иргэн Монгол Улсын хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан анхны тохиолдол байсан. Эдгээр давааг туулж 2012 онд Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн- өмгөөлөгч, уг Холбооны анхны гадаад өмгөөлөгч болсон нь надад бахархалтай, дурсамжтай үйл явдал байсан төдийгүй өмгөөлөгч болсондоо одоо ч баяртай байдаг.

Та өөрийн хуулийн фирмийнхээ талаар товч танилцуулна уу?

Монгол Улс болон БНСУ-ын хамтарсан хөрөнгө оруулалттай Өмгөөллийн “Эл Би Партнерс” ХХН-ийг Монгол Улсын хуульч, өмгөөлөгч Г.Буянтай хамтран 2013 онд үүсгэн байгуулсан.

Манай хуулийн фирм нь Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын гишүүн байгууллага бөгөөд гадаад хамтын ажиллагааны хүрээнд БНСУ-аас Монгол Улсад суугаа элчин сайдын яам, БНСУ-ын “With You” хуулийн фирм, БНХАУ-ын “Beijing Sun god /Huhhot/” хуулийн фирм, БНСУ-ын Хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг дэмжих төв /АТ/, БНСУ-ын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын Монгол дахь төлөөлөгчийн газар /Kotra/, БНСУ-ын Койка олон улсын байгууллага зэрэг байгууллагатай хамтран ажиллаж байгаа. БНСУ-д манай хуулийн фирмийн

төлөөлөгчийн газар байгуулагдсан.

Манай хуулийн фирмд Монгол Улсад болон хилийн чанадад хууль зүйн боловсрол эзэмшсэн, англи, орос, солонгос зэрэг гадаад хэлний мэдлэгтэй, мэргэжлийн ур чадвартай монгол хуульч-өмгөөлөгчид ажилладаг. Түүнчлэн гадаад хуульчид тухайлбал, Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгэлтэй, БНХАУ-ын хуульч, өмгөөлөгч Ван Уй Лин, Ван Вэй Ли Си нар ажилладаг. Манай хуулийн фирмийн зарим хуульчид БНСУ-ын Күүгмин их сургуулийн магистрт амжилттай суралцаж байна.

Гадаад улсын иргэн, хуулийн этгээдүүд ихэвчлэн ямар асуудлаар хууль зүйн үйлчилгээ авахаар танай хуулийн фирмд ханддаг вэ?

Манай хуулийн фирм үүсгэн байгуулагдсан цагаасаа өнөөдрийг хүртэл хууль зүйн зөвлөх үйлчилгээ, өмгөөллийн үйлчилгээ, эрдэм шинжилгээ, судалгааны ажил гэсэн үндсэн 3 чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Манай хуулийн фирмээс БНСУ-ын хөрөнгө оруулагч, бизнесийн салбарынхан хууль зүйн зөвлөх үйлчилгээг түлхүү авдаг.

Тодруулбал, компани үүсгэн байгуулах, хувьцаа худалдах, худалдан авахтай холбоотойгоор баримт бичиг, гэрээ хэлцлийн төсөл боловсруулах, бүртгүүлэх, компанийн үйл ажиллагаанд хууль зүйн талаас нь байнгын зөвлөгөө өгөх, бизнесийн үйл ажиллагаа эрхлэн явуулахтай холбоотойгоор бизнесийн эрх зүйн орчны талаар хууль зүйн зөвлөгөө өгөх, төрөл бүрийн гэрээний төсөл боловсруулах, хянах, хууль зүйн дүгнэлт, дүн шинжилгээ хийх зэрэг цогц үйлчилгээг үзүүлдэг.

Гадаадын иргэн, хуулийн этгээд Монгол Улсад бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд ямар хүндрэл бэрхшээл учирч байна вэ?

Гадаадын иргэн, хуулийн этгээд нь тухайн улсынхаа хууль, эрх зүйн орчинг сайн мэдэхгүйгээс бизнесийн үйл ажиллагаанд нь эрсдэл бий болох тохиолдол байдаг. Тухайлбал, ямар нэгэн тусгай зөвшөөрөл бүхий компанийн хувьцааг худалдан авахдаа урьдчилан тухайн компанитай холбоотой мэдээллийг нягталж шалгахгүйгээр, түүнчлэн компанийн хувьцааг худалдан авахтай холбогдуулан татварын хувь хэмжээг судлахгүйгээр хувьцаа эзэмшигчийн зөвшөөрөлгүй хуурамч итгэмжлэл зэрэгт итгэж гэрээ байгуулж эрсдэлд орох

тохиолдол байдаг. Тиймээс тухайн улсынхаа хууль, эрх зүй, татварын орчинг судалж, эрх бүхий байгууллагад хандаж, урьдчилан хууль зүйн дүгнэлт гаргуулж бизнесийн үйл ажиллагаагаа эхлүүлэх нь зүйтэй.

Монгол Улсын төрийн байгууллагын үйлчилгээний тухайд жил ирэх тусам хүртээмжтэй болж байгаа бөгөөд БНСУ, Монгол Улсын төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа хөгжиж байгаа нь хоёр улсын эдийн засгийн салбарт таатай орчинг бий болгож байна. Тухайлбал, Монгол Улсад БНСУ-ын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын Монгол дахь төлөөлөгчийн газар /KOTRA/ албан ёсоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн тухайд Монгол Улсад хамгийн үйлчилгээ авдаг байгууллага нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар, Гадаад иргэн, харьяатын газар, Үндэсний хөгжлийн газар, Татварын байгууллагууд бөгөөд гадаадын иргэн, хуулийн этгээдүүд нь төрийн үйлчилгээ авахдаа “Invest in Mongolia” Нэг цэгээс бүх үйлчилгээний төв авдаг болсон нь сайшаалтай байна. Цаашид гадаадын хөрөнгө оруулагч нарт бизнес эрхлэхэд нь хууль зүйн хувьд таатай нөхцөлийг бий болгох зорилгоор хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах гэж байгаа нь Монгол Улсын эдийн засаг тэр дундаа стратегийн ач холбогдол бүхий салбарыг хөгжүүлэх боломжийг бий болгож байна.

Танай фирм Солонгос улсын ямар, ямар байгууллагад хууль зүйн үйлчилгээ үзүүлж байсан бэ?

Манай хуулийн фирмийн тухайд Монгол Улсын төдийгүй БНСУ-ын иргэн, хуулийн этгээдэд хууль зүйн үйлчилгээг үзүүлж байна. Тухайлбал, БНСУ-ын Хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг дэмжих төв /АТ/ төрийн байгууллагад Монголд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн импортлох асуудлаар хууль зүйн зөвлөх үйлчилгээг 3 дахь жилдээ үзүүлж байна.

Түүнчлэн БНСУ-ын Инчоно нисэх буудал, “Миат” ТӨХК хооронд хамтран ажиллах гэрээ байгуулах асуудлаар хууль зүйн дүгнэлт гаргасан. БНСУ-ын “Ашиана эйрлайнс” ХК-ийн Монгол дахь төлөөлөгчийн газрыг байгуулахтай холбогдуулан хууль зүйн үйлчилгээ үзүүлсэн. БНСУ-ын хуулийн этгээд “Лотте консон” ХК Монгол Улсын хуулийн этгээд “Монгол Алт Корпораци” ХХК-ны

хэрэгжүүлж буй Улаанбаатар хотод байрлах "МАК Хаяат Реженси зочид буудлын төсөл / УБ цамхаг/" дээр ажиллахад нь хууль зүйн дүгнэлт гаргаж өгсөн. "Улаанбаатар хотын хөгжлийн корпораци" ХК, БНСУ-ын "Воожин Ар Ди Си" ХХК-ийн хооронд хамтран ажиллах гэрээг боловсруулахад хууль зүйн үйлчилгээ үзүүлсэн. БНСУ-ын хөрөнгө оруулалттай "Плэйлэнд" ХХК-ийн хувьцаа эзэмшигч нэмэхтэй холбогдуулан БНСУ-ын "Плэйтайм групп" ХК, Монгол Улсын "Алтай холдинг" ХХК, "БДБ трейдинг" ХХК хооронд хувьцаа худалдах худалдан авах гэрээ, эрх шилжүүлэх гэрээ, хамтран ажиллах гэрээ байгуулахад хууль зүйн үйлчилгээ үзүүлсэн. Түүнчлэн, БНСУ-ын KBS телевизийн олон ангит киноны зохиогчийн эрхийг албан ёсоор авахтай холбогдуулан хууль зүйн зөвлөх үйлчилгээг үзүүлж байна.

Монгол Улсад бизнес нь амжилттай явж байгаа олон компани байгаа боловч зарим компанийн хувьд бизнесийн үйл ажиллагаа нь эрсдэлд орсон тохиолдол байдаг. Бизнесийн үйл ажиллагаа нь эрсдэлд орж байгаа гол шалтгаан нь ихэвчлэн гэрээ байгуулахдаа гэрээний нөгөө талаа сайн судлаагүйгээс тэдэнд залилуулж мөнгө санхүү, эдийн засгийн хувьд хохирдог. Сүүлийн үед гадаадын хөрөнгө оруулалттай компанийн хувьцааг худалдан авахтай холбоотой төрөл бүрийн маргаан шүүхээр хянагдаж байна.

Иймд компанийн хувьцааг худалдан авахтай холбоотойгоор дараах зүйлсийг зайлшгүй мэдэх шаардлагатай. Холбогдох төрийн байгууллагаас хувьцаа эзэмшигчийн дэлгэрэнгүй лавлагаа, бусдад өр төлбөртэй эсэх лавлагаа, тухайн компанид холбогдох маргаан шүүхээр хянагдаж байгаа эсэх лавлагаа зэрэг албан ёсны бичиг баримтыг гаргуулж, шалгасны үндсэн дээр тухайн компанийн хувьцааг худалдан авах шийдвэрээ гаргах, гэрээ байгуулахдаа ч хуульчид хандаж мэргэжлийн зөвлөгөө авч байх нь зүйтэй.

Хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулахдаа юуг илүү хардаг вэ? Бид аль чиглэлд түлхүү анхаарах хэрэгтэй вэ?

Хөрөнгө оруулагчид Монгол Улсад хөрөнгө оруулахдаа Монгол Улсын хууль эрх зүйн тогтвортой орчин, эрхлэх бизнесийн салбарын эрэлт хэрэгцээ, ашиг олох боломжтой эсэхийг гаоллон анхаардаг. Монгол Улсын Засгийн газраас баталсан Алсын хараа 2050 МУ-ын урт хугацааны

хөгжлийн бодлогод Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод гадаадын хөрөнгө оруулагчдад таатай олон зорилтыг дэвшүүлсэн байна. Энэхүү бодлогын баримт бичгийн 2 дугаар хавсралт ("Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа)-ад "...Мэдээллийн технологи болон цахим худалдааны салбар дахь хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах, хөрөнгө оруулагчдын ашиг сонирхлыг дэмжих, худалдааны зохицуулалтын хуулийг батлах, барилгын материал, малын гаралтай болон уул уурхайн түүхий эдийг боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх гадаадын хөрөнгө оруулалтыг урамшуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, боловсролд хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт үзүүлэх тогтолцоог бий болгох" зэрэг алсыг харсан зохицуулалтууд багтсан байна.

Эдгээр зорилтууд бодитоор хэрэгжсэнээр гадаадын хөрөнгө оруулагчид Монгол Улсад тогтвортой, үр дүнтэй хөрөнгө оруулалт хийх нөхцөл боломж бүх талаар бүрдэнэ гэж үзэж байна.

Хөрөнгө оруулалтын орчноо сайжруулахаар олон өөрчлөлтүүдийг хийж байна. Та Монгол дахь хөрөнгө оруулалтын болон бизнесийн орчныг хэрхэн үнэлж байна вэ?

БНСУ нь Дэлхийн худалдааны байгууллагад 1968 оны 7 дугаар сарын 2-ны өдөр элссэн байна. Дэлхийн худалдааны байгууллагаас гаргасан 2015 оны тайланд 2008 оны дэлхийн эдийн засгийн хямралын дараагаар БНСУ-ын экспорт давамгайлсан эдийн засаг маш хурдан хугацаанд сэргэсэн нь гадаад худалдаагаар эрчимжүүлж, түүнийг дэмжих макро эдийн засгийн болон санхүүгийн олон талын бодлого хэрэгжүүлсний үр дүн байсан. Монгол Улсын зах зээл жижиг, далайд гарцгүй, хөрш хоёр их гүрнээс нэлээд хамааралтай байдаг боловч байгалийн баялгаар дэлхийн 10 том улсын тоонд багтдаг. Монгол Улс, БНСУ-ын эдийн засгийн харилцаа өнгөрсөн 30 жилийн хугацаанд харилцан идэвх чармайлтаар дүүрэн байж, хоёр орны төр засгийн тэргүүнүүд олон санал, санаачилгыг дэвшүүлж байсан.

Худалдаа эдийн засаг, шинжлэх ухаан, технологи, соёл, боловсрол, аялал жуулчлал, дэд бүтцийн салбар зэрэг салбарт хамтран ажиллах, түүнчлэн БНСУ-ын анагаах

ухаан болон дэд бүтцийн салбарын мэргэжилтнүүдийн туршлагыг нэвтрүүлэхэд хөрөнгө оруулалт хийх нь Монгол Улсын олон улсад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, дотоод эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, улсын төсөв, ажлын байр нэмэгдүүлэх ач холбогдолтой байна.

Би хуульч хүний хувьд хууль тогтоомжид орж буй өөрчлөлтийг анхааралтай судалдаг. Монгол Улсын бизнесийн хууль тогтоомж түүний дотор татварын хуулиудад нилээд өөрчлөлт орсон. Эдгээр хуулиуд хөрөнгө оруулагчдад хамгийн их хамаатай байдаг. Монгол Улс татварын дарамт багатай улс оронд тооцогддог. Монгол Улсын Засгийн газар 2019 онд татварын шинэчлэлийг хоёр дахь удаагаа хийж, Улсын Их Хурлаас Татварын Ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиудыг шинэчилсэн найруулгаар баталж, эдгээрийг дагалдаж 30 орчим хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан.

Засгийн газрын хийсэн энэхүү шинэчлэлийн үр дүнд татвар төлөгчдийн татварын дарамт дахин буурсан бөгөөд уг шинэчлэл нь татвар төлөгчийн татвар төлөх, татварын тайлан тушаах хүндрэл чирэгдлийг багасгахад чиглэсэн байсан.

Тухайлбал, хөрөнгө оруулагчдыг татах зорилгоор, гадаад зах зээл дээр нээлттэй арилжиж байгаа Монгол Улсын үнэт цаасыг худалдан авч, хөрөнгө оруулсан тохиолдолд эдгээр үнэт цааснаас олсон хүү, ногдол ашгийн орлогод ногдуулах татвар 5 хувь байхаар бууруулсан. Эдгээр жишээнээс үзвэл хөрөнгө оруулагчдын татварын эрх зүйн орчин улам таатай болж буйг харж болохоор байна.

Цаг гаргаж дэлгэрэнгүй ярилцлага өгсөн танд баярлалаа.



Хөрөнгө оруулалтын дэмжлэг, сурталчилгааны алба мэргэжилтэн
Б. УНДРАХ



МОНГОЛ, СОЛОНГОСЫН НӨХӨРЛӨЛИЙН БЭЛЭГ ТЭМДЭГ “НОГООН ХЭРЭМ” ТӨСӨЛ

Монгол Улсын цөлжилтийг бууруулах, шар шороон шуургатай тэмцэх зорилго бүхий Монгол-Солонгосын “Ногоон хэрэм” төслийг 14 дэх жилдээ хэрэгжүүлж байна.

Тодруулбал, Монгол, БНСУ 2005 онд шар шороон шуурга, цөлжилтөөс сэргийлэх ойжуулалтын төсөл хэрэгжүүлэх дээд хэмжээний хэлэлцээр хийж, 2006 онд БОАЖЯ болон Солонгосын Ойн агентлаг хамтран ажиллах санамж бичиг байгуулж байжээ. Үүний дүнд БНСУ-ын 11.8 сая ам.долларын хөрөнгөөр Өмнөговь аймгийн Даланзадгад сум, Булган сумын нутаг дахь Баянзаг болон Төв аймгийн Лүн суманд нийт 45 га талбайд мод үржүүлгийн газар байгуулж, 3046 га талбайг ойжуулсан юм.

Дээрх гурван сум нь Монгол Улсад шар шороон шуурга дэгдэх гол эх үүсвэр хэмээн үзэж, цөлжилтөд тэсвэртэй тоорой, сухай, жигд, бургас, хайлаас, гүйлс, бүйлс зэрэг 20 төрлийн нэг сая мод суулгасан нь амжилттай ургаж байгаа аж.

Төслийн хүрээнд ойжуулсан газрыг шат дараатайгаар Монголын талд хүлээлгэн өгч байгаа юм. 2017 оноос эдүгээг хүртэл 2200 гаруй га талбайг Монголын талд хүлээлгэн өгсөн байна. Үлдсэн 821 га талбайг энэ онд хүлээлгэн өгөх бөгөөд ингэхдээ тухайн ойг арчлах зардал, тоног төхөөрөмжийн хамт гардуулахаар болжээ. Ингэснээр Монгол Улсын Засгийн газар ойг цаашид арчлах, шинээр мод нэмж тарих, талбайг өргөжүүлэх бүрэн боломжтой болно гэдгийг “Ногоон хэрэм” төслийн захирал Сон Ин Гён хэллээ. Цөлжиж буй газарт мод тарьж, улмаар ойжуулах бүрэн боломжтойг үлгэрлэн харуулсан нь энэ төслийн гол үр дүн юм. Төслөөс олон иргэн, улс төрч санаа авч, мод тарьж, байгаль орчноо хамгаална гэдэгт итгэж буйгаа мөн онцолсон юм.

“Ногоон хэрэм” төсөл ийнхүү 2016 онд дууссан ч хоёр орны Засгийн газраас үргэлжлүүлэх нь зөв хэмээн үзэж, тухайн оны тавдугаар сарын 18-нд Монгол-Солонгос хоёр

орны Төрийн дээд хэмжээний зөвшилцөл, долоодугаар сарын 17-нд Цөлжилт болон шар шороон шуургатай тэмцэх чиглэлээр хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг байгуулжээ.

Энэ хүрээнд “Ногоон хэрэм” төслийн II шатыг 2017-2022 онд хэрэгжүүлэх болж, Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 16



дугаар хороо буюу Дамбадаржаагийн нутаг дэвсгэрийн 40 га талбайд Хотын ой буюу “Монгол-Солонгосын найрамдлын цэцэрлэгт хүрээлэн” байгуулах ажлыг эхлүүлсэн юм. Төслийн эхний шат шар шороон шуургатай тэмцэх байсан бол II шат нийслэлийн агаарын бохирдлыг бууруулахад чиглэж байна. Нийт есөн сая ам.долларын өртөгтэй энэхүү төслийн бүтээн байгуулалт 50.8

хувьтай үргэлжилж байна. Энгийн цэцэрлэгт хүрээлэнд иргэд амарч, зугаалдаг бол хотын ойгоос модны ашиг тус, түүнийг ургуулах, арчлах зэрэг ойн талаар бүхий л мэдлэг, мэдээллийг авдаг болно гэдгийг мөн төслийн захирал онцолсон юм.

БНСУ-ын Ерөнхий сайд Ли Наг Ён Монгол Улсад 2019 оны гуравдугаар сард айлчлахдаа тус цэцэрлэгт хүрээлэнгийн бүтээн байгуулалтын ажилтай танилцаж, дурсгалын мод тарьсан юм. Энэ талаар “Ногоон хэрэм” төслийн захирал Сон Ин Гён, “Ерөнхий сайд айлчлалынхаа үеэр энэ төслийг цааш үргэлжлүүлэх, ашиг тустай төсөл хэрэгжүүлэх боломж байгаа гэсэн сэдлийг бидэнд өгсөн. Тиймээс III шатыг хэрэгжүүлэх эсэх талаар нарийвчилсан судалгааг хийж байна” гэсэн юм.

Монгол Улсын шар шороон шуурганы дэгдэлтийг зогсоох, Монгол орны цөлжилт, шар шороон шуургаанаас сэргийлэх, Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулахад бодит хувь нэмрээ оруулж буй “Ногоон хэрэм” төсөл нь Монгол, БНСУ-ын нөхөрлөлийн бэлгэ тэмдэг болно хэмээн төсөл хэрэгжүүлэгчид үзэж байна.

Төслийг дуусахаас өмнө хэд хэдэн асуудлыг БОАЖЯ болон холбогдох байгууллагуудаар шийдвэрлүүлэх шаардлагатай байгааг мөн төслийн багийнхан хэлж байлаа. Тухайлбал, “Монгол-Солонгосын найрамдлын цэцэрлэгт хүрээлэн”-г цаашид хөгжүүлэх, тохижуулах менежментийн төлөвлөгөөг нэн даруй боловсруулах, цэцэрлэгт хүрээлэн ойролцоох төв замаас шууд орох зам тавих асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгаа аж. Одоогоор шууд орох зам байхгүй тул гэр хороолол дундуур, холуур тойрч ордог байна. Мөн цэцэрлэгт хүрээлэн байгуулж буй газарт спорт цогцолбор барих зөвшөөрөл олгосон зэрэг асуудал үүсжээ. Тиймээс дээрх асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгааг төслийн зохицуулагч Н.Баянхишиг хэлсэн юм.

ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛАХ ҮЕ ШАТ:

Монгол Улсад зөвшөөрөгдөх Гадаадын хөрөнгө оруулалтын хэлбэр:

- Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулах /100% гадаадын хөрөнгө оруулалттай болон хамтарсан компани/
- Хувьцаа, өрийн бичиг, бусад төрлийн үнэт цаасыг худалдан авах;
- Компанийг нэгтгэх, нийлүүлэх замаар хөрөнгө оруулалт хийх;
- Концесс, бүтээгдэхүүн хуваах, маркетинг, менежментийн болон бусад гэрээ байгуулах;
- Санхүүгийн түрээс /лизинг/-ийн болон франчайзийн хэлбэрийн хөрөнгө оруулалт хийх;
- Хуулиар хориглоогүй бусад хөрөнгө оруулалтын хэлбэр.

Гадаадын хөрөнгө оруулагч нь аж ахуйн нэгж байгуулахад: Улсын бүртгэлийн газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт Гадаадын хөрөнгө оруулалттай хязгаарлагдмал хариуцлагатай компани болон гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрыг бүртгүүлнэ.

Хэрэв Гадаадын төрийн өмчит хуулийн этгээд уул уурхай, банк санхүү, мэдээлэл, харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа явуулах компанийн нийт хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг эзэмших бол Үндэсний хөгжлийн газраас зөвшөөрөл авсны дараа УБЕГ-т бүртгүүлнэ.

Шийдвэрлэх хугацаа

- Шинээр ГХОААН байгуулах – ажлын 5 хоногт
- Шинээр ГХЭТ-ийн төлөөлөгчийн газар байгуулах – ажлын 5 хоногт
- Хөрөнгө оруулагчийн тодорхойлолт- ажлын 3 хоногт
- Оршин суух визийн зөвшөөрөл-ажлын 3-5 хоногт
- Тамга ажлын 2 өдөрт

БҮРТГҮҮЛЭХ ҮЕ ШАТ:



ХЭРЭВ ГАДААДЫН ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИ БОЛ:



ОНООСОН НЭРИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ АВАХАД БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ:

- Иргэний үнэмлэх
- Итгэмжлэл
- Мөнгө тушаасан баримт
- <http://les.burtgel.gov.mn/>

ГАДААДЫН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР:

- УБ X, XI, XIII маягтыг бөглөх
- Гадаадын хуулийн этгээдийн танилцуулга, дүрмийн хуулбар
- Гадаадын хуулийн этгээдийн гэрчилгээний хуулбар
- Төлөөлөгчийн газар байгуулах тухай эх компанийн шийдвэр /эх хувиар баталгаат орчуулгын хамт/
- Төлөөлөгчийн газрын журам /2 хувь, баталгаат орчуулга 1 хувь/
- Албан ёсны хаяг
- Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт
- Итгэмжлэл /хөрөнгө оруулагч бол шаардлагагүй/
- <http://burtgel.gov.mn/service/index.php/les-newlist/les-new>

ГХОААН-ИЙГ ШИНЭЭР БАЙГУУЛАХАД БҮРДҮҮЛЭГ БАРИМТ, БИЧИГ:


- УБ XII, XIII маягтыг бөглөх
- Оноосон нэрийн баталгаажуулалтын хуудас /эх хувь/
- Данс нээсэн хуудас
- ГХОААН байгуулах тухай шийдвэрийн эх хувь /баталгаат орчуулгын хамт/
- Гадаадын төрийн өмчит хуулийн этгээдийн зөвшөөрөл /уул уурхай, банк, санхүү, мэдээлэл, харилцаа холбооны салбарт компанийн нийт хувьцааны 33%/
- Гэрээ, дүрэм 2 хувь
- Паспортын хуулбар /хөрөнгө оруулагч нь хувь хүн бол/
- Хуулийн этгээдийн гэрчилгээ, дүрмийн хуулбар /хөрөнгө оруулагч нь хуулийн этгээд бол/
- Хөрөнгө оруулалтыг нотлох баримт / Гадаадын хөрөнгө оруулагч тус бүрийн 100 мянган ам.долларыг гадаад улсаас оруулж ирсэнийг нотлох баримт/
- Албан ёсны хаяг
- Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт
- Итгэмжлэл /хөрөнгө оруулагч бол шаардлагагүй/
- <http://burtgel.gov.mn/service/index.php/les-newlist/les-new>

ГХОААН-ИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, УДИРДАХ АЛБАН ТУШААЛТАН ВИЗИЙН ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭХДЭЭ ДАРААХ БИЧИГ БАРИМТЫГ БҮРДҮҮЛНЭ:


1. Үндэсний хөгжлийн газраас олгосон хөрөнгө оруулагчийн тодорхойлолт
2. Байгууллагын визийн зөвшөөрөл хүссэн албан бичиг /байгууллагын үйл ажиллагааны тухай мэдээлэл, гадаадын иргэнийг урих үндэслэл, виз авах боломжтой Дипломат төлөөлөгчийн газар, Консулын газрыг тодорхойлох/
3. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /урьд нь бүртгүүлж байгаагүй бол/
4. Гадаад иргэний паспортын хуулбар / хүчинтэй хугацаа 6 сараас доошгүй/
5. Хүсэлт гаргаж буй байгууллагын ажилтны ажлын газрын үнэмлэх эсхүл хууль ёсны итгэмжлэх
6. Визийн зөвшөөрлийн хураамж 1000 / нэг хүн/
7. Шаардлагатай тохиолдолд нэмэлт бичиг баримт авчрах
8. <http://mn.immigration.gov.mn/>,
9. <https://evisa.mn/>



February Newsletter



April Newsletter






March Newsletter



May Newsletter



-  Засгийн газрын 2-р байр, Нэгдсэн Үндэстний Гудамж, Улаанбаатар 15160
-  www.nda.gov.mn
-  [/investmongolgov](https://www.facebook.com/investmongolgov)

-  [/ndagovMN](https://twitter.com/ndagovMN)
-  info@nda.gov.mn
-  976-51-261589, 7777 8787

investmongolia.com

